

АГУУЛГА

МУИС-ийн захирлын мэндчилгээ	2
МУИС-ийн эрхэм зорилго, Үнэт зүйлс	3
I БҮЛЭГ. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	
МУИС-ийн танилцуулга	4
Бүрэлдэхүүн сургууль	
• Шинжлэх ухааны сургууль	5
• Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	6
• Бизнесийн сургууль	7
• Хууль зүйн сургууль	10
• Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	12
Сургалтын нэгдсэн алба	13
II БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР	
Бакалаврын хөтөлбөр	15
Магистрын хөтөлбөр	22
Докторын хөтөлбөр	23
III БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦ	
Хичээлийн жилийн хуанли	25
SiSi мэдээллийн систем	27
Суралцагчийн хүсэлт, санал гомдлыг хүлээн авах, барагдуулах	39
Сургуулиас олгох бичиг баримт /албан ба албан бус/	39
Сургалтын төлбөр, үйлчилгээний хөлс	40
IV БҮЛЭГ. СУРАЛЦАГЧИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН	
Суралцагчийн ёс зүйн хэм хэмжээ	43
Суралцагчийн мэдлэг, чадварын үнэлгээ	44
Чөлөө авах, үргэлжлүүлэн суралцах	46
Сургууль хооронд шилжих	47
Сургуулиас чөлөөлөх, хасах	47
Төгсөгчдөд тавигдах нийтлэг шаардлага	48
МУИС-ийн дүрэм журмын товъёог	51
V БҮЛЭГ. СУРАЛЦАГЧИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ	
Сургалтын тэтгэлэг	52
Солилцооны хөтөлбөр	52
Суралцагчдын хөдөлмөр эрхлэлт	53
МУИС-ийн номын сан	53
Дотуур байр	55
Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ	56
Хууль зүйн зөвөлгөө өгөх төв	57
Сэтгэл зүйн оношилгоо, сургалт, судалгааны төв	57
VI БҮЛЭГ. ШААРДЛАГАТАЙ УТАС БОЛОН ХИЧЭЭЛИЙН БАЙР, ӨРӨӨНИЙ ДУГААР	

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын Их Сургуульд шинээр элсэн орсон суралцагч та бүхэнд хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе!

МУИС-ийн эрдмийн алтан босгоор хамгийн шилдэг, хамгийн авьяастай суралцагч алхан орж, Монгол улсын ирээдүйг цогцлоон бүтээгч-боловсролтой иргэн болон төгсөн гардаг гэдгээр бид бахархдаг билээ.

Монгол улсад өнөөдөр өөрсдийн гараараа “юм” бүтээдэг, бие даан шийдвэр гаргах чадвартай, өргөн мэдлэг боловсролтой, ёс зүйтэй боловсон хүчин шаардлагатай байна. МУИС-д хийгдэж буй шинэчлэл нь нийгмийн энэ бодит хэрэгцээг хангахад чиглэсэн, уян хатан бүтэц, таатай орчинг суралцагч танд зориулж бий болгох зорилготой юм.

МУИС нь өнгөрсөн хичээлийн жилд сургалтын хөтөлбөрүүдээ шинэчлэн, сонголтыг илүү өргөн болгож, суралцагчдад хичээл, багш, мэргэжлээ сонгох бололцоог нээж өгсөн шинэ бүтэц зохион байгуулалтанд орлоо. Мөн түүнчлэн суралцах ая тухтай орчин бүрэлдүүлэхэд зориулан хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлж, суралцагчийн үйлчилгээний нэгжийг шинэчлэн зохион байгууллаа.

Сонголтыг эрхэмлэсэн сургалтын тогтолцоо нь бүх түвшинд өрсөлдөөнийг өрнүүлж, шударга өрсөлдөөн нь чанартай сургалтыг бий болгоно.

Амжилттай сурах нь асуудал шийдэлт, идэвхтэй эрэл хайгуул, тууштай бүтээлч хөдөлмөрийн үр дүн байдаг.

Та бүхний хувьд шинэ хичээлийн жил ирээдүйн их амжилтын эхлэл байна гэдэгт итгэлтэй байна. МУИС-ийн оюутан та бүхэн Монгол улсын ирээдүйг бүтээнэ.

Хүндэтгэсэн, А. ГАЛТБАЯР

ЭРХЭМ ЗОРИЛГО

Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн болон технологийн салбарт шинэ мэдлэг бүтээж, түгээн дэлгэрүүлдэг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий үндэсний их сургууль байж, улс орны хөгжилд далайцтай хувь нэмэр оруулна.

АЛСЫН ХАРАА

Дэлхийн стандартад нийцсэн, монгол улсын хөгжил дэвшлийн тулгуур болсон үндэсний загвар судалгааны их сургууль байна.

УРИА

МУИС-ийн Оюутан - Монголын ирээдүй

ҮНЭТ ЗҮЙЛС

- Академик эрх чөлөө
- Сайн засаглал
- Нийгмийн ёс зүй
- Уламжлал ба шинэчлэл

I БҮЛЭГ. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

МУИС-ийн ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын ууган их сургууль (МУИС) нь анх 1942 оны 10 дугаар сарын 5-нд Физик, математикийн, Анагаахын, Мал эмнэлэг, зоотехникийн 3 факультеттайгаар хичээл сургалтаа эхэлсэнээс хойш эдүгээ 72 жилийн хугацаанд эх орны хөгжил дэвшилд гар бие оролцогч 70000 гаруй дээд боловсролтой мэргэжилтэн төгсгөн гаргажээ. Мөн МУИС-ийн түүхэн хөгжлийн явцад одоогийн МУБИС, ХААИС, АШУИС, ШУТИС, ХИС, Ховд их сургуулиуд төрөн гарч, Монгол улсын дээд боловсролын систем төлөвшин хөгжихөд үнэтэй хувь нэмрээ оруулсан билээ.

Манай сургуулийн нийт багш нарын 40 гаруй хувь нь эрдмийн зэрэгтэй бөгөөд 2013 онд Монгол улсаас олон улсын нэр хүндтэй сэтгүүлд нийтлүүлсэн бүтээлийн гуравны нэгийг МУИС-ийн эрдэмтэн багш, судлаач нарын бүтээл эзэлж байна. Манай хамт олон дэлхийн шилдэг их сургуулиудын жишигт хүрэхийн төлөө, судалгааны их сургууль болох зорилт дэвшүүлэн, Монгол улсын дээд боловсролын шинэчлэлийг түүчээлэн ажиллаж байна.

МУИС нь нийслэл Улаанбаатар хотод 5 бүрэлдэхүүн сургуультайгаас гадна Орхон, Завхан аймагт тус тус салбар сургуультай.

МУИС-ийн БҮТЭЦ



БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ

ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

Тус сургууль нь байгалийн ухаан, нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухаан гэсэн 3 салбарт 19 тэнхимтэй үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Байгалийн ухааны салбар: Тус салбар нь 1942 оноос буюу МУИС анх байгуулагдсанаас хойш сургалт эрдэм шинжилгээний ажлыг тасралтгүй явуулж ирсэн арвин туршлагатай хамт олон билээ. Одоо математик, физик, хими, биологи, газарзүй, геологи геофизикийн мэргэжлийн 6 тэнхимтэйгээр дахин зохион байгуулагдсан.

Математик, хими, физик, биологи, газарзүй, геологийн шинжлэх ухааны чиглэлээр олон улсын хөгжлийн нийтлэг чиг хандлагад нийцсэн эрдэм шинжилгээ, шаталсан сургалт явуулж улс орны хөгжилд далайцтэй хувь нэмэр оруулах үндэсний сургалт судалгааны төв байх эрхэм зорилготойгоор ажиллаж байна. Монголын тэргүүлэх эрдэмтэд болох олон багш нар энэ тэнхимүүдэд өөрийн мэдлэг, туршлагаа оюутан суралцагчдад хуваалцан сургахад өөрийн хувь нэмрээ оруулдаг юм.

Хими, физик, биологи, газарзүйн сургалтын лабораториудаар тоноглогдсон, Өвөрзайсан, Хонин нугад мэргэжлийн дадлага хийх талбай, хотхонтой.

ЕБС-ийн багш нарт Мэргэжлийн дидактик, Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүй, Боловсролын чанар үнэлгээ зэрэг сэдвээр БСШУЯ-ны зөвшөөрөлтэй кредит олгох тусгай сургалтыг явуулахаас гадна математик, физик, хими, биологи, газарзүй гэх мэт улсын мэргэжлийн олимпиадыг голлон зохион байгуулдаг.

Нийгмийн ухааны салбар: антропологи-археологи, боловсрол сэтгэл судлал, эдийн засаг, улс төр судлал, социологи-нийгмийн ажил, сэтгүүл зүй олон нийтийн харилцааны 6 тэнхимтэй.

Социологи-Нийгмийн ажлын тэнхмийн багш нар нийгмийн ялгарал, давхраажил, чөлөөт цаг, амьдралын хэв маяг, нийгмийн гаж үзэгдэл, гэмт хэрэг, иргэдийн улс төрийн оролцоо, ядуурал, шилжих хөдөлгөөн зэрэг Монголын нийгэмд тулгамдсан олон асуудлуудыг хамруулан судалгаа хийдэг. Эдийн засгийн тэнхим нь зах зээлийн эдийн засгийн онолын хичээлийг заах хичээлийн хөтөлбөрийг Монголд анх удаа боловсруулан гаргаж, шилжилтийн үеийн эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийн онолын үндсийг тайлбарлан таниулах чиглэлээр ажиллаж, эдийн засгийн онолын мэргэжлээр оюутан сургадаг үндэсний тэргүүлэх эрдэмтэдтэй. Боловсрол, сэтгэл судлалын тэнхим нь 1992-1993 оны хичээлийн жилээс сэтгэл судлалын мэргэжлээр анхны элсэлтээ авч сэтгэл судлаач, сэтгэл судлалын багш мэргэжилтэн бэлтгэж эхэлжээ. Тус тэнхимийн дэргэд “Сэтгэц оношилгоо, сургалт судалгааны лаборатори” үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд ижил чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын зарим байгууллагатай хамтран ажилладаг.

Хүмүүнлэгийн ухааны салбар: философи шашин судлал, түүх, монгол хэл хэл шинжлэл, утга зохиол урлаг судлал, Их Британи Америк судлал, Европ судлал, Ази судлалын 7 тэнхимтэй. Монгол хэл, хэлшинжлэлийн болон утга зохиол урлагийн тэнхим нь эх хэл, бичиг соёл хийгээд монголчуудын уламжлалт мэдлэг ухааны өв хөмрөг болсон монгол, төвд, манж хэлээрх сурвалж бичгүүдийг болон Монголын нүүдэлчдийн соёл урлаг, ёс заншил, сэтгэлгээний онцлог зэрэг бичгийн дурсгалд олон зуун жилээр хэрхэн уламжлагдаж ирснийг судлах, Монголын сонгодог уран зохиол, Монгол ардын аман зохиолын баялаг өв, монгол хэлний онцлог шинжийг судлах томхон төвүүд бөгөөд дэлхийн жишигт хүрсэн хэл, соёлын тогтолцоот боловсролтой чадварлаг судлаач болон багш мэргэжилтнийг бакалавр ба ахисан түвшинд бэлтгэн гаргадаг. Философи шашин судлалын тэнхим нь философи, шашны янз бүрийн уламжлал, үзэл баримтлал, онол болон түүхийн өргөн хүрээг хамарсан хичээлүүдийг суралцагчдад санал болгодог бөгөөд философийн түүх, ёс зүй, гоо зүй, метафизик, эпистемологи зэрэг философийн үндсэн агуулга, дэлхийн гол шашнуудын гол номлол сургаалуудын түүхэн хөгжил, урсгал чиглэлүүдийн талаархи өргөн мэдлэгийг олгоно. Хэл, орон судлалын салбарт гадаад хэлний бодлого, сургалт заах арга зүйн салбарт тэргүүлэх төв байж, гадаад хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн, Монгол улсаа төлөөлөн олон улсад ажиллах мэргэжлийн ур чадвартай манлайлагч боловсон хүчин бэлтгэж байна. Тус салбарт Монгол улсын хэмжээнд хамгийн олон буюу 15 гадаад хэл заадаг. 40 гаруй оюутны тэтгэлэгтэй, гадаад улсад 2 хүртэлх жилээр суралцах, дадлага хийх боломж оюутнуудад нээлттэй.

Тус сургуульд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд нь хамгийн уян хатан, сонголт ихтэй, оюутны чадвар бололцоо, сурах эрх чөлөөг хангахуйц байдаг. Дээрх мэргэжлийн тэнхимийн эрдэмтэн багш, судлаачид АНУ, Япон, Герман, Англи, ОХУ, БНСУ, БНХАУ, Чех, Канад, Голланд зэрэг олон орны эрдэмтэдтэй хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд тус тэнхимээс Монгол Улсын Ардын багш, гавьяат багш, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, УИХ-ын гишүүн, Засгийн Газрын гишүүн зэрэг олон арван алдартнууд төрөн гарчээ.

Тус сургуульд хэрэгжиж байгаа хими, сэтгүүл зүй, улс төр судлал, англи хэл шинжлэл, орос хэл шинжлэл, франц хэл судлал, япон хэл судлал, герман хэл судлал, хятад хэл шинжлэл, солонгос судлал, турк судлал хөтөлбөрүүд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлүүлсэн.

Манай төгсөгчид нийгмийн аль ч салбарт ажиллах мэдлэг чадвартай байдаг бөгөөд ажлын байраар хангагдсан үзүүлэлт сайн. Манай сургуульд сурснаар ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудад багшлах, эрдэм шинжилгээний байгууллага, төр болон төрийн бус хувийн хэвшлийн байгууллагад ажиллах өргөн боломж Та бүгдийн өмнө нээлттэй байна.

Та бүхний эрдмийн оргил өөд мацах их үйл өлзийтэй байг.

ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ

Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургууль (ХШУИС) нь МУИС-ийн бүтцийн өөрчлөлтийн дагуу МУИС-ийн хуучин бүрэлдэхүүн болох МТС, МКС, ГГС, ББС, ХХИС, ФЭС гэх мэт салбар сургуулиудаас инженер-технологи, хэрэглээний шинжлэх ухааны чиглэлтэй сургалтын хөтөлбөр, судлаач багш нар, оюутнуудыг нэгтгэн 2013 оны 12-р сард шинэчлэн байгуулагдсан.

Сургуулийн эрхэм зорилго:

Тус сургууль нь цаашид шинжлэх ухааныг техникийн болон нийгмийн өргөн олон салбарт хэрэглэх мэдлэг оюуны үндсэн цөм, тэргүүлэгч байж техник, технологи ба нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шинжлэх ухаанчаар шийдвэрлэх, нийгэмдээ үйлчлэх, улс орны хөгжилд дорвитой хувь нэмрээ оруулах, иргэний өндөр ухамсар, соёлтой шилдэг мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилго тавин ажиллаж байна.

Сургуулийн бүтэц, бүрэлдэхүүн

ХШУИС-д 2013-2014 оны хичээлийн жилийн байдлаар 107 үндсэн багш ажиллаж байгаагийн 38 нь эрдмийн зэрэг цолтой байна. Мөн түүнчлэн зөвлөх профессор 13, гэрээт багш, профессор 12 ажиллаж байна.

ХШУИС нь Эрдмийн зөвлөл, захиргааны зөвлөл, сургуулийн болон тэнхимийн хөтөлбөрийн дэд хорооноос гадна мэргэжлийн дөрвөн тэнхим, судалгааны төвүүд, сургалтын алба, оюутанд үйлчлэх төв гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна.

Сургалтын алба, оюутанд үзүүлэх үйлчилгээ

ХШУИС-ийн сургалтын алба нь оюутан бүрийн зөвлөгч, чиглүүлэгч нь байна. Сургалтын албанаас оюутан бүрд дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Оюутны хичээл сонголт, сургалтын календарчилсан төлөвлөгөө, хувь хүний ахиц дэвшил, цагийн менежмент хийх зөвлөгөө өгөх
- Сургалтын эерэг орчинг бүрдүүлэн сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх
- Сурах хугацаандаа багшийг даган судалгааны ажил хийх, мэргэжлийн олимпиад, уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх
- Хувь хүний хөгжлийг дэмжин нийгэм, ёс зүй, танин мэдэхүйн хөгжилд зориулагдсан үйл ажиллагаа явуулах
- Дотоодын байгууллын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах

- Оюутны клуб, дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжих
- Урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах

Давуу тал

- Гадаадын тэргүүлэх их дээд сургуулиуд болон эрдмийн зэрэг цолттой, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн профессор багш нараар хичээл заалган судалгаа шинжилгээний ажил дагалдан хийх боломжтой.
- Оюутны бие даан суралцах төв нь 50 гаруй суудалтай, тогтмол хэрэглэгддэг 4000 гаруй ном, сурах бичиг, электрон ном, гарын авлагаар үйлчилдэг.
- Мөн утасгүй сүлжээ, онлайн ном захиалах системийг үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.

Хичээлийн байр, анги танхим

ХШУИС нь 200 гаруй компьютер бүхий сургалтын лабораторитай, тэнхим, лабораторийн компьютерууд нь сургуулийн дотоод сүлжээнд холбогдсон ба тус сургуулийн оюутнууд интернэтийн үйлчилгээг байнга үнэгүй авах боломжтой.

БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ


Эрхэм зорилго

Бизнесийн удирдлагын чиглэлээр олон улсын хөгжлийн нийтлэг хандлагад нийцсэн эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа явуулж, даяаршиж буй дэлхийд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Стратеги

- Чанартай сургалт + Бүтээлчээр суралцах хандлага + Онол практикийн хосолсон мэдлэг, ур чадвартай мэргэжилтэн.
- Чадварлаг судлаач + Таатай орчин + Шинэлэг, шилдэг, бүтээлч судалгаа

Сургуулийн бүтэц



Бизнесийн сургуулийн онцлог, давуу талууд

- Санхүү, банк, даатгал, нягтлан бодох бүртгэл, менежмент, маркетинг, худалдаа, аялал жуулчлал, зочлох үйлчилгээ зэрэг бизнесийн удирдлагын хөтөлбөрүүдээс сонгон суралцах боломжтой
- Олон улсын магадлан итгэмжлэлийн ACBSP байгууллагын өндөр үнэлгээгээр магадлан итгэмжилсэн хөтөлбөрүүдтэй.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дипломтой төгсөх боломжтой.
- Сургалтандаа Их Британийн их сургуульд хэрэгжүүлдэг чанарын стандартыг мөрдөж, орчин үеийн сургалтын арга, технологийг нэвтрүүлсэн.
- Мэргэжлийн хичээлүүдийг явуулах анги танхим, лабораториуд, орчин үеийн сургалтын техник хэрэгслүүдээр бүрэн хангагдсан.
- Монгол улсдаа нэр хүндтэй мэргэжилтнүүдийг бэлтгэж ирсэн, олон арван жилийн баялаг туршлагатай.
- Нийт багш нарын 50% эрдмийн зэрэг цолтой,
- Багшлах бүрэлдэхүүн нь судалгаа, шинжилгээний болон заах арга зүйн өндөр ур чадварыг эзэмшсэн.
- Гадаадын нэр хүндтэй хэд хэдэн их дээд сургуультай хамтран ажиллаж, хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.
- Санхүүч, Банкир, Залуу менежер, New Time-21, Альфа, Нэгүл зэрэг оюутны мэргэжлийн клубүүдэд хамрагдаж, өөрийгөө хөгжүүлэх боломжтой.
- Бизнесийн томоохон компаниуд болон ТББ-уудаас зарлагдсан төрөл бүрийн тэтгэлэг, санхүүжилтэд хамрагдах өргөн боломжтой.
- Улсын ба бүсийн чанартай мэргэжлийн олимпиадад тогтмол оролцож, өндөр амжилтуудыг үзүүлдэг.
- Ажил олгогчдын зүгээс манай төгсөгчдийг хамгийн түрүүнд ажлын байрт санал болгодог

Таны эзэмших мэдлэг, ур чадварууд

- Математик, компьютер, гадаад хэлний болон нийгмийн ухааны суурь хичээлүүдийг судалж мэдлэгээ гүнзгийрүүлнэ.
- Бизнесийн удирдлагын ухааны төрөл бүрийн хичээлүүдэд хамрагдаж, багаар ажиллах, удирдах, манлайлах, ажил хэргийг хөтлөн явуулах ур чадваруудыг эзэмшинэ.
- Зарчимч, шударга, нөхөрсөг, ёс суртахууны хувьд төлөвшсөн иргэн болно.
- Харилцааны өндөр чадвартай болж, бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэх дадал, чадварт суралцана.
- Гадаадын аль нэг хэл дээр мэргэжлийн ном, сурах бичиг ашиглах чадварыг эзэмшинэ.
- Онолын болон судалгааны семинарт илтгэл хэлэлцүүлж, бие даан судалгаа хийх чадварт суралцана.

Бизнесийн сургуулийн Сургалтын хөтөлбөрүүд

Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрөөр төгсөгчид нь Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн бүх шатны байгууллагууд хувийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудад нягтлан бодогч, санхүүгийн шинжээч, эдийн засагч, их дээд сургуулиудад нягтлан бодох бүртгэлийн багш, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, санхүүгийн хяналт, шалгалт хийх, төрөл бүрийн ажил, албан тушаалд ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийг сонгон суралцах оюутнууд Нягтлан бодох бүртгэл, Нягтлан бодох бүртгэл татвар, Нягтлан бодох бүртгэл, хяналт шалгалт, Нягтлан бодох бүртгэл мэдээлэл зүй гэсэн төрөлжсөн чиглэлүүдээр мэргэшин суралцах боломжтой.

Санхүү, Банк хөтөлбөрөөр төгсөгчид нь санхүүгийн менежер, санхүүч санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх, төсөв төлөвлөгөө зохиох, тайлан тэнцлийг судалж шинжилгээ хийх, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, үнэлэх, санхүүгийн арга хэрэгслүүдийн оновчтой хослолыг хангах, санхүүгийн зах зээл дээр байгууллагаа төлөөлөн ажиллах, санхүүгийн хяналт,

шалгалт хийх, теллер, нягтлан бодогч, зээлийн эдийн засагч, эрсдлийн болон хөрөнгө зохицуулалтын мэргэжилтэн, хянан шалгагч, гүйцэтгэх болон удирдах ажил, төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар, төсвийн бодлого, төлөвлөлтийн газар, худалдан авах ажиллагааны газар, санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар, хэлтсүүдэд мэргэжилтэн, эдийн засагч, шинжээч зэрэг ажил, үүргийг гүйцэтгэж байна. Санхүүгийн хөтөлбөрийг сонгон суралцах оюутнууд Санхүүгийн менежмент, Банк, Санхүү, Санхүүгийн менежмент мэдээлэл зүй гэсэн төрөлжсөн чиглэлүүдээр мэргэшин суралцах боломжтой.

Даатгал хөтөлбөрөөр төгсөгчид нь даатгалын менежер, мэргэжилтэн, даатгалын компанийн санхүүгийн үйл ажиллагаанд менежмент хийх, үйл ажиллагааны эрсдлийг тодорхойлох, үнэлэх, хохирлыг хэмжээг математик арга, загвараар урьдчилан тооцоолох чадварыг эзэмшинэ.

Бизнесийн удирдлага /Их Британийн NCC олон улсын хөтөлбөр/ хөтөлбөрөөр төгсөгчид нь олон улсын хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн захиргааны болон төрийн бус байгууллагуудын хүрээнд менежментийн нэгэн адилаар бүх төрлийн төлөвлөгөөг стратегийн болон үйл ажиллагааны түвшинд боловсруулж байгууллагад стратегич менежерийн үүрэг гүйцэтгэх, байгууллагын бүх талын үйл ажиллагааг нэгтгэх, хоорондын уялдаа холбоог зангидах, удирдан зохион байгуулах, манлайлах, байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг олон улсад гүйцэтгэж байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бизнесийн удирдлагын дипломтой төгсөнө. Бүх хичээл англи хэл дээр явагдах бөгөөд Их Британид суралцах боломжтой.

Менежмент хөтөлбөрөөр төгсөгчид нь аж ахуйн нэгж байгууллагын хүрээнд бүх төрлийн төлөвлөгөөг стратегийн болон үйл ажиллагааны түвшинд боловсруулж байгууллагад стратегич менежерийн үүрэг гүйцэтгэх, байгууллагын бүх талын үйл ажиллагааг нэгтгэн зангидах, хооронд нь уялдуулах, удирдан зохион байгуулах, манлайлах, байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, эдийн засаг, зах зээлийн орчны шинжилгээ судалгаа хийж мэдээлэл боловсруулах, дүгнэлт гаргах зэрэг ажил, үүргийг гүйцэтгэж байна. Менежментийн хөтөлбөрийг сонгон суралцах оюутнууд Бизнесийн менежмент, Үйлдвэрлэлийн менежмент, Хүний нөөцийн менежмент гэсэн төрөлжсөн чиглэлүүдээр мэргэшин суралцах боломжтой.

Маркетинг хөтөлбөрөөр төгсөгчид нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн захиргааны болон төрийн бус байгууллагуудад маркетинг, борлуулалт, зар сурталчилгааны чиглэлээр ажилладаг. Төгсөгчид нь байгууллагын захирал, гүйцэтгэх захирал, маркетингийн ерөнхий менежер, маркетинг, борлуулалтын алба болон олон нийттэй харилцах алба, хэлтэс, газарт захирал, менежер, маркетингийн судалгаа, харилцагчийн үйлчилгээ, зар сурталчилгааны менежер, их дээд сургуульд маркетингийн багш, судлаач, төрийн байгууллагад эдийн засгийн хэлтэс, тасгуудад мэргэжилтэн, зэрэг хариуцлагатай ажил, үүргийг гүйцэтгэж байна. Мөн сургалт, судалгаа, дизайны болон эрдэм шинжилгээний байгууллагуудад судлаач, рекламны агентлаг, мэргэжлийн дизайны студи, продакшн зэрэгт байгууллагын дүр төрхийг бүрдүүлэгч, дизайнер зэрэг ажлуудыг нэр төртэйгээр гүйцэтгэж байна. Маркетингийн хөтөлбөрийг сонгон суралцах оюутнууд Маркетинг, Зар сурталчилгаа гэсэн төрөлжсөн чиглэлүүдээр мэргэшин суралцах боломжтой.

Худалдаа хөтөлбөрөөр төгсөгчид нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, олон улсын тээвэр зуучийн болон хөрөнгө оруулалттай байгууллагад гадаад худалдааны менежер, Гаалийн ерөнхий газар, Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Үйлдвэр, Худалдаа, Эдийн засгийн хөгжлийн яамд зэрэг төрийн захиргааны болон төрийн бус бусад байгууллагуудад гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын менежер, гаалийн ажилтан, экспорт, импортын нэгжийн удирдах ажилтан, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагуудад судлаач зэрэг ажил, үүргийг гүйцэтгэж байна. Худалдааны хөтөлбөрийг сонгон суралцах оюутнууд Худалдааны менежмент, Олон улсын худалдаа, Гаалийн удирдлага гэсэн чиглэлүүдээр мэргэшин суралцах боломжтой.

Үйлчилгээний хөтөлбөрөөр элсэгч аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, бизнесийн удирдлагын хосолсон мэдлэг эзэмшиж, одны зэрэглэлтэй зочид буудал, томоохон тур операторын бизнесийн үйл ажиллагаа, аялал жуулчлалын бүс нутаг төлөвлөлттэй танилцаж туршлага хуримтлуулна. Суралцагч аялал жуулчлал, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний бизнесийн шилдэг хөтөлбөрөөр суралцаж салбарын тухай ойлголт, төсөөлөлтэй болсны дараа аялал жуулчлал эсвэл зочлох үйлчилгээний удирдлагын аль чиглэлээр мэргэшихээ сонгоно. Төгсөгчдөд төрийн

байгууллагад аялал жуулчлал, зочид буудал, зоогийн газар эрхэлсэн түшмэл, улсын байцаагч, их дээд сургуулиудад багш, судлаач, аялал жуулчлалын компани, жуулчны бааз, түр оператор, зочид буудал, зоогийн газар, амралт, сувиллын газар, түр оператор, уурхайн кэмпд менежер, зохион байгуулагч зэрэг ажлын байр үргэлж нээлттэй байдаг. Түүнчлэн гадаад хэлний өндөр мэдлэгтэй бол олон улсын сүлжээний зочид буудал, зоогийн газар, түр операторын гэрээт тэтгэлгээр суралцаж төсгөөд уг байгууллагад менежер, зохион байгуулагч, хөтөч-орчуулагчийн албан тушаалд улмаар гадаадын салбаруудад ажиллах боломжтой.

Хичээлийн байр:

Бизнесийн сургууль нь МУИС-ийн хичээлийн 4, 5, 8 дугаар байруудад хичээллэнэ.

Хичээлийн нийт 40 танхим, компьютерийн 18 лабораторийн ангитай.

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

МУИС-ийн Хууль Зүйн сургууль нь эх орондоо дээд боловсролтой хуульчдыг анх бэлтгэсэн үеийн эрх зүйчдийн эрдмийн өлгий билээ. 1960 оны 5 сарын 24-ний өдрийн МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний №262 тоот тогтоолоор МУИС-д Хууль цаазын ангийг нээсэн бөгөөд эдүгээ тус сургууль нь дээд боловсролтой эрх зүйчдийг бэлтгэх, хууль зүйн шинжлэх ухааны дотоодод төдийгүй гадаадад хүлээн зөвшөөрөгдсөн сургууль болон өсөн бэхжсэн байна.

Сургуулийн эрхэм зорилго:

Хууль зүйн эрдэм судлал, сургалтын талбарт үндэсний тэргүүлэх төв байж, нийгэмд манлайлах чадвартай, хууль, шударга ёсны төлөө үнэнч ажиллах, мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс зүйтэй эрх зүйчдийг бэлтгэхэд оршино.

Сургуулийн бүтэц, бүрэлдэхүүн

Хууль зүйн сургууль нь эрх зүй, олон улсын эрх зүй хөтөлбөрөөр сургалт явуулдаг мэргэжлийн 5 тэнхим, сургалт судалгааны 4 төв, 46 үндсэн багш (удирдах албан тушаалтныг оролцуулан), гэрээт 11 багш, гадаад (япон, солонгос) 8 багш, нийт 65 багштай сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж байна.

Манай сургуулийн багш нарын 40 гаруй хувь нь гадаадын өндөр хөгжилтэй, тухайлбал, АНУ, Япон, БНСУ, ХБНГУ, ОХУ, Украин зэрэг улсад магистр, докторын зэрэг хамгаалсан. Багш нарын 50 гаруй хувь нь хууль зүйн ухааны болон шинжлэх ухааны докторын зэрэгтэй.

Хууль зүйн сургуулийн сургалт:

МУИС-ийн Хууль зүйн сургууль нь дараахь түвшинд сургалт явуулдаг:

- Бакалаврын сургалт (LL.B) Өдөр – 5 жил, орой - 2.5 жил, эчнээ - 3.5жил (120-150 багц цаг)
- Магистрантурын сургалт (LL.M) Өдөр - 2 жил (32-36 багц цаг)
- Докторантурын сургалт (LL.D) Өдөр - 3 жил, эчнээ - 4 жил (60 багц цаг)

Мэргэжил: Эрх зүйч

Мэргэшил: Олон улсын эрх зүй (3-р түвшингээс эхлэн олон улсын эрх зүйч /Японы эрх зүй, Солонгосын эрх зүй/ мэргэжлийг сонгон суралцах боломжтой).

Давуу тал

• МУИС-ийн Хууль зүйн сургуулийн сургалтад 2005 оноос хэрэг шинжлэх аргыг (**case study**) тогтмол хэрэглэх болсон. Хэрэг (тохиолдол) шинжлэх арга нь хууль зүйн сургуулийн сургалтын чанарыг сайжруулах, зах зээлийн болон ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх зорилгод нийцэж байгаа билээ.

• Суралцагч нийт судлах хичээлийн гуравны нэгээс доошгүй хувийг сонирхсон чиглэлээрээ сонгож, мэргэших боломжоор хангагдсан.

- Хичээлийн байр байршил сайтай, тохилог, сургалт явуулах стандарт шаардлагыг хангасан

• Хичээлийн болон дадлагын анги, танхимуудын хүрэлцээ, төрөлжсөн кабинетуудын хүчин чадал нь сайн


• 2005 онд Японы Нагояагийн их сургуулийн Хууль зүйн сургууль, 2011 онд БНСУ-ын Күүкмений их сургуулийн Хууль зүйн сургуультай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу Японы болон Солонгосын эрх зүйн боловсрол, судалгааны төвүүдийг манай сургуулийн дэргэд байгуулсан бөгөөд Япон болон Солонгосын эрх зүйн сургалтыг япон, солонгос хэл дээр явуулснаар Япон, Солонгосын эрх зүйн мэдлэгтэй Япон, Солонгос хэлийг өндөр түвшинд эзэмшсэн эрх зүйчдийг бэлтгэж байна.

• Суралцагчдыг дэмжих, идэвхижүүлэх үүднээс Хууль зүйн сургууль тус сургуулийнхаа Оюутны зөвлөл, оюутны “Энтимема” клуб, “Беркли” клуб, “English speaking club”, “Залуу Криминологич” зэрэг клубуудтай хамтарч ажиллаж байна.

Хичээлийн байр, анги танхим

МУИС-ийн Хууль зүйн сургууль (МУИС-ийн хичээлийн 3Б байр) нь нийт 2494.5 м² талбайтай, 20 хичээлийн анги танхимуудыг эзэмшиж, сургалт, судалгааны ажил явуулж байна. Тус сургуулийн хичээлийн байр нь нэг ээлжиндээ 600 гаруй оюутан нэгэн зэрэг хичээллэх хүчин чадалтай бөгөөд одоогийн байдлаар лекцийн заал 3, анги танхим 16, компьютерийн танхим 1, номын сангийн уншлагын заал 2, албан ажлын өрөө 16, оюутны дотуур байр 1, буфет 1 гэсэн байдлаар үйл ажиллагаагаа явуулж байгаа болно.

Хууль зүйн сургууль хичээлийн бүх анги, танхимд видео проектор, дэлгэц суурилуулж, лекц, семинар, дасгалын хичээлд ашиглаж байна. Мөн зарим нэг ангид сургалтын үйл ажиллагааг хөндлөнгөөс хянах зорилгоор хяналтын камер байрлуулсан.



Лекцийн хоёр танхимыг орчин үеийн техник, технологийн шийдлээр засаж тохижуулсан, тухайлбал: *101 тоот заал нь:*

- 50-60 суудалтай;
- Дуу тусгаарлагч ханатай;



- Утсан микрофон 2 ш, 1 проектортой;
- Чихэвчтэй зөөврийн микрофон 2 ш.

331 тоот анги нь:

- 140-150 шатлалсан суудалтай;
- Дуу тусгаарлагч ханатай;
- Утсан микрофон 2 ш, 2 проектортой;
- Чихэвчтэй зөөврийн микрофон 2 ш;
- Агааржуулалтын систем (дулааны улиралд сэрүүн агаараар, сэрүүн улиралд халуун агаараар үлээнэ)

Тус сургуулийн буфет нь 10-15 хүний суудалтай, хичээлийн өдрүүдэд 8-10 цагаар бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнээр оюутнуудад үйлчилдэг. Үнийн хувьд харьцангуй хямд, хагас боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн хадгалах хөргүүр-3, мөн бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан.

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ

Даяарчлалын өнөөгийн нөхцөлд Монгол улсын эрх ашгийг хамгаалах, олон улсын харилцаанд Монгол улсын эзлэх байр суурийг бататгах, олон улсын харилцааны чиг хандлагад нийцсэн гадаад бодлого, практик үйл ажиллагаа явуулах, иргэн төвтэй засаглалын тогтолцоог бэхжүүлэх, удирдахуйн ухаан суурилсан ОУХНУ-ын чиглэлээр чадварлаг мэргэжилтэн бэлтгэх нь тус сургуулийн зорилт юм.

1991 онд МУИС-ийн захирлын тушаалаар Хэл бичгийн факультетын гадаад хэлний тэнхмийг Өрнө дахины, Дорно дахины тэнхим болгон зохион байгуулж, улмаар МУИС-ийн захирлын 343 дугаар тушаалаар Өрнө дахины хэл, Дорно дахины судлал, Орос хэлний тэнхмийн бааз дээр түшиглэн ОУХС-ийг байгуулж, 1991-1992 оны хичээлийн жилээс сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлжээ.

ОУХНУ Сургууль нь 2013 оны 12-р сард ОУХ-ны сургууль дээр түшиглэн байгуулагдсан. Дэлхийн Олон улсын харилцааны Академи, Их, Дээд сургуулиудтай үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж хамтран ажилладаг. Энэ нь манай сургуулийн сургалтын үйл ажиллагааг дэлхийн түвшинд гаргаж, уялдуулан зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Цаашид ОУХНУС нь салбар мэргэжлээрээ улсдаа тэргүүлэх сургалт, эрдэм шинжилгээний төв болох зорилттой.

ОУХС-ийн сургалтын хөтөлбөрийг бакалавр, магистрын түвшинд олон улсын стандартад нийцүүлж шинэчилж 2004 оноос эхлэн бакалаврын сургалтын хөтөлбөрөөр оюутан элсүүлж авч эхэлсэн. Өнөөгийн байдлаар манай сургуульд бакалаврын 800 гаруй оюутан, 200 аад магистрант, 50 орчим докторант суралцаж байна.

2014-2015 оны хичээлийн жилээс Олон улсын харилцаа, Нийтийн удирдлага гэсэн 2 хөтөлбөрөөр элсэлт авч байна. Мөн бакалавр, магистр, докторын (Ph.D) сургалтанд үргэлжлүүлэн суралцах боломжтой. ОУХНУС-ийн бакалаврын сургалт нийт 120 багц цагийн хөтөлбөрийг 4 жилийн хугацаанд судлах төлөвлөгөөтэй.

Давуу талууд:

2008 онд ОУХ, ОУЭЗХ мэргэжлийн стандартыг анх удаа боловсруулан батлуулснаар бусад ижил төстэй их сургуулиуд жишиг болж дагаж мөрдөж байна. Тус сургуулийн ОУХ, ОУЭЗХ-ны хөтөлбөр нь 2012 онд БМИҮЗөвлөлөөр магадлан итгэмжлэгдсэн.

Суралцагчид олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцаа, олон улсын эрх зүй, төрийн захиргаа, нийтийн удирдлагын чиглэлээр заавал үзэх болон сонгон суралцах хичээлийг судална. Мөн бүх оюутнууд англи хэлийг бүрэн эзэмшихийн зэрэгцээ 2 дахь гадаад хэлний (орос, герман, франц, япон, хятад, солонгос хэлний аль нэгийг сонгон) зохих түвшний мэдлэгтэй болно.

Манай сургуулийг төгсөгчид Монгол улсын гадаад харилцаа эрхэлсэн төрийн ба төрийн бус байгууллагууд, ЭСЯ-ууд, олон улсын байгууллага, мөн төрийн захиргааны төв болон орон нутгийн засаг захиргааны бүх шатны байгууллагад ажиллах боломжтой.

ОУХНУС нь 2005 онд шинэ хичээлийн байртай (хичээлийн Ү байр) болж МУИС-ийн хэмжээнд сургалт явуулах нөхцөл бололцоогоор бүрэн хангагдсан сургуулийн нэг болсон. Сургалт явуулах албан тасалгааг стандарт шаардлагад нийцүүлсэн 360 суудал бүхий лекцийн 3 танхим, 254 суудал бүхий 7 семинарын танхим, 59 суудал бүхий 3 лингафоны кабинеттэй үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн МУИС-ийн ОУХНУС-ийн Оюутны бие даах төвд 60 гаруй оюутанд үйлчлэх орчин үеийн тохилог ширээ сандал, компьютерийн лабротори байгуулан тохижуулж сургуулийнхаа сургалт, эрдэм шинжилгээний агуулга, хөтөлбөрт нийцсэн ном хэвлэлээр номын фондоо байнга баяжуулж ирсэн юм.

Эрхэм хүндэт оюутан, шавь нар аа! Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын салбарт мэргэжилтэн болох хүсэл эрмэлзэлдээ хүрэхийн тулд таны мэдлэг зөвхөн Монгол орон, гадаад хэлний мэдлэгээр хязгаарлагдахгүй, дэлхийн хэмжээнд сэтгэж, дэлхийн хэмжээнд харьцах өндөр соёл, өргөн мэдлэг, мэргэжлийн нарийн үр чадварыг эзэмшсэн байх ёстой. Энэ бүхний төлөө манай сургуулийн эрдэмтэн багш нар та бүхэнтэйгээ хамтран ажиллахад бэлэн байна.

СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБАНЫ ТАНИЛЦУУЛГА

Сургалтын нэгдсэн алба (СНА) нь оюутан таныг МУИС-ийн оюутан болох хүсэлт гаргахаас авахуулаад төгсөх хүртэл үйлчлэхээс гадна төгссөний дараа ч мөн холбоотой ажилладаг “Оюутан төвтэй” нэгж юм. Бид МУИС-ийн суралцагч таныг дээд боловсролын зэрэгтэй иргэн болон төлөвшихөд тань хамгийн ойр ажиллаж МУИС-ийн мянга орчим багш нараар хичээл заалгах сонголтыг хийх боломжоор хангах баг бүрэлдэхүүн юм.

Сургалтын нэгдсэн албаны үндсэн чиг үүрэг

Сургалтын нэгдсэн төв болон салбар алба нь дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Суралцагч таныг суралцуулж дээд боловсролын зэрэг олгох хөтөлбөрийг МУИС-ийн тэргүүний эрдэмтэн багш нараас бүрдэх хөтөлбөрийн хороод олон талын судалгаа, шинжилгээн дээр үндэслэн боловсруулдаг билээ. СНА нь эдгээр хөтөлбөрийн хороодтой нягт хамтран ажиллаж, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж, үнэлгээ өгдөг.
- Хөтөлбөрийн хүрээнд сургалтын үйл ажиллагаа эрхлэх бөгөөд үүнд элсэлт, оюутны бүртгэл, сургалтын технологи, төгсөлт зэрэг үйл ажиллагааг Монгол улсын хууль, тогтоол, МУИС-ийн дүрэм, Сургалтын журам болон бусад холбогдох бичиг баримтын дагуу явуулна.
- Сургалтын чанарын удирдлагыг хэрэгжүүлж, сургалтын хөтөлбөрийн болон технологийн хэрэгжилтэд мониторинг хийх. Үүний тулд оюутнаас сэтгэл ханамжийн санал асуулга, өргөдөл гомдол хүлээн авах, багш нарын хичээлд хөндлөнгийн мониторинг хийх ажлыг зохион байгуулж хяналт тавина. Мөн суралцагчийн мэдлэг, чадварыг зөвөөр дүгнэх, энэ үйл ажиллагаанд орчин үеийн сургалт, судалгааны техник хэрэгсэл, арга барил ашиглах асуудлыг удирдан зохион байгуулна.
- Сургалтын үйл ажиллагааг дэмжсэн таатай орчин бүрдүүлэх, ном, мэдээллийн хангамжийг сайжруулах бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих; сургалтанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, сургалттай холбогдолтой мэдээллийн сан бүрдүүлнэ.

Бид танд Сургалтын нэгдсэн албаадаараа дамжуулан дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

1. Суралцагчын суралцах үйл ажиллагааг дэмжихтэй холбогдуулан:
 - Хичээл, мэргэжил сонгоход зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа болон бусад шаардлагатай мэдээллээр хангах;
 - Суралцагчын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, хариу өгөх, холбогдох нэгжээр шийдвэрлүүлэх;
 - Суралцагчын суралцах хугацааны холбогдох тодорхойлолт олгох;
 - МУИС-ийн хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагаа, Эрдмийн баяр зэрэг сургалттай холбоотой тэмдэглэлт үйл ажиллагаануудыг зохион байгуулах;
2. Суралцагчын суралцах хугацаанд гарч буй нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч, тусламж дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан:
 - Оюутныг дотуур байранд оруулах;
 - Суралцагчийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах;
 - Суралцагчын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж оюутанд мэдээлэх, хөдөлмөрийн харилцаа, зах зээлд бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулах;
 - Суралцагчын нийгмийн бусад шаардлагатай үйлчилгээнд хамруулах;
 - Оюутны байгууллагуудтай хамтран ажиллах;
 - Суралцагчын соёл, хүмүүжил, урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах.

Та доорхи бичиг баримтуудыг өөрийн харьяаллын Сургалтын албанаас авч болно. Үүнд:

- Дүнгийн тодорхойлолтыг автомат машинаас авах эсвэл өөрийн эрхээр SiSi системээс хэвлэн авч СА-ны эрхлэгчийн гарын үсэг, тамгаар баталгаажуулна.
- Чөлөө авахад чөлөө хүсэх маягыг СА-ны оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтнээс авч бөглөн зааварлагчид өгнө.
- Үргэлжлүүлэн суралцах хүсэлт гаргахдаа СА-ны оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэнд хандана.
- Хичээлийн хуваарь, хичээл сонголт, баталгаажуулалт хийхтэй холбоотой асуудал гарвал СА-ны сургалтын технологи хариуцсан мэргэжилтэнд хандана.

Та бүхний оюутан насыг сайхан дурсамжаар дүүрэн өнгөрүүлэхэд бид тусална!

II БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР

Дээд боловсролын Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө нь “ерөнхий суурь”, “мэргэжлийн суурь”, “үндсэн мэргэжил” (Major) болон “чөлөөт сонголт” (Free elective) гэсэн бүтэцтэй байна.

Бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн хөтөлбөр

№	МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль	Сонгох боломжтой бакалаврын үндсэн мэргэжлийн хөтөлбөр
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ (ШУС)	Багш-байгалийн ухааны боловсрол /физик, хими, биологи, газарзүй/, Багш-математикийн боловсрол, Байгаль орчны зайнаас тандан судлал, Биологи, Биологийн нөөц судлал, Биохими, Газар зохион байгуулалт, Газарзүй, Геологи, Геофизик, Математик, Физик, Хими, Хот ба бүс нутгийн төлөвлөлт, Экологи,
1.1.	<i>ШУС-ийн Байгалийн ухааны салбар</i>	
1.2.	<i>ШУС-ийн Нийгмийн ухааны салбар</i>	Антропологи, Архив судлал Нийгмийн ажил, Социологи, Сэтгүүл зүй, Сэтгэл судлал, Улс төр судлал, Эдийн засаг,
1.3.	<i>ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар</i>	Археологи, Багш-гадаад хэлний боловсрол, Багш-монгол хэл уран зохиолын боловсрол, Багш-нийгмийн ухааны боловсрол, Гадаад хэлний орчуулга, Олон улс-орон судлал/Араб, Герман, Испани, Итали, Их Британи, Америк, Орос, Польш, Солонгос, Турк, Франц, Хятад, Чех, Япон/ Түүх, Урлаг судлал, Утга зохиол судлал, Философи, Хэл шинжлэл, Хэл-уран зохиол, Шашин судлал,
2	БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	Аялал жуулчлал, Бизнесийн удирдлага, Даатгал, Зочлох үйлчилгээ, Маркетинг, Менежмент, Нягтлан бодох бүртгэл, Санхүү-банк, Худалдаа,
3	ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ	Нийтийн удирдлага, Олон улсын харилцаа,
4	ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	Эрх зүй
5	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ	Байгаль орчныг хамгаалах технологи, Био-инженерчлэл, Биотехнологи, Компьютерийн сүлжээ, Компьютерийн ухаан, Материал судлал, Мэдээллийн систем, Мэдээллийн технологи, Нано шинжлэх ухаан-инженерчлэл, Ойн үйлдвэрлэлийн техник технологи, Програм хангамж, Статистик, Сэргээгдэх эрчим хүч, Ус судлал, Химийн инженерчлэл, Холбооны технологи, Хүрээлэн буй орчин судлал, Хэрэглээний математик, Хэрэглээний хими, Цаг уур, Цөмийн инженерчлэл, Электрон системийн автоматжуулалт.

Ерөнхий суурь хичээл.

Ерөнхий суурь хичээл бол ерөнхий боловсролын сургуульд үзсэн хичээлийн давталт биш бөгөөд цаашид сонгон сурах мэргэжлийн суурь мэдлэг, ур чадварыг суулгах улмаар тодорхой чиглэлээр гүнзгийрэн сурах нөхцлийг хангасан ахисан түвшний багц хичээл юм.

Ерөнхий суурь хичээлийг судалснаар оюутан либерал арт боловсрол буюу нийгмийн идэвхтэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай шүүмжлэлт, бүтээлч, логик сэтгэлгээнд суралцаж, санаачлан хийдэг, рациональ шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, хөрвөдөг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг, ур чадвар эзэмшсэн, их сургуулийн боловсролтой, чадварлаг, ёс зүйтэй иргэн болж хөгжинө.

Ерөнхий суурь хичээлийн зорилго. Ерөнхий суурь хичээл нь оюутанд дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндэс буюу ойлгомжтой ярих, бичих, тоон болон тоон бүс мэдээллийг боловсруулах, олон ургальч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэх, багаар үр дүнтэй хамтарч ажиллах, хариуцлагатай байх, харилцан суралцах мэдлэг, ур чадварыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр эзэмшүүлэх зорилготой.

Ерөнхий суурь хичээлээр оюутны олж авах мэдлэг, ур чадвар. Ерөнхий суурь хичээл нь МУИС-ийн бакалаврын сургалтад тавигдах шаардлагыг хангахад чиглэсэн, 1. Нийгэм хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухааны суурь мэдлэг, 2. Аливаа мэдлэг туршлагаа амьдралд бүтээлчээр бодитой ашиглах ур чадвар олгох гэсэн үндсэн зорилгыг агуулсан академик, дээд боловсролын суурь хичээл мөн. Мэдлэг олгох зорилго бол амьдарч буй нийгэм, байгаль орчны юмс үзэгдэл, харилцаа холбооны тухай шинжлэх ухаанч, рациональ мэдлэгтэй, логикоор сэтгэдэг бие хүнийг бэлтгэхэд чиглэдэг бол ур чадвар эзэмшсэнээр оюутан өөрийн боловсрол, мэргэжлийн мэдлэг чадварыг амьдрал дээр амжилттай хэрэгжүүлэх ур чадвар эзэмшсэн, нийгмийн идэвхтэй гишүүн болж хөгжихөд тусална. Түүнчлэн ерөнхий суурь хичээлийг судалснаар оюутан өөрийн хүсэл сонирхол, авьяас чадварт тулгуурлан ирээдүйн мэргэжлээ ухамсартай сонгон суралцах боломжтой болно.

Ерөнхий суурь хичээлүүдийг судлах. МУИС-ийн оюутан ерөнхий суурийн агуулгын чиглэл бүрээр заасан багц цагийг авахын тулд бүрэлдэхүүн сургууль, тэнхимүүдээс санал болгож байгаа хичээлүүдээс өөрийн судлахыг хүссэн хичээлийг СиСи мэдээллийн системээр сонгоно. Жишээ нь байгалийн ухааны 6 багц цагийн хичээлийг судлахын тулд санал болгож буй хичээлүүдээс хүссэн 2 хичээлээ сонгож судлах ёстой.

ШУС-ийн Ерөнхий суурийн багц цаг 36, ХШУИС, ОУХНУС, ХЗС, БС-иудад Ерөнхий суурийн багц цаг 30 байна. Ерөнхий суурийн хичээлээр 50 болон түүнээс дээш оюутан сонгосон тохиолдолд бүлэг үүсгэнэ. Харин гадаад хэлний сургалтын тухайд энэ тоог бууруулж тогтоох асуудлыг тусад нь журмаар шийдвэрлэнэ. Заасан шаардлагыг хангаагүй тохиолдол дахин сонголт хийлгэх, эсвэл ижил төстэй хичээлтэй нийлүүлэх эрхийг МУИС-ийн сургалтын нэгдсэн алба эдэлнэ.

Ерөнхий суурь хичээлийн үнэлгээ. Ерөнхий суурь хичээлийн үнэлгээний тогтолцоо нь МУИС-ийн сургалтын журамд заасны дагуу зохицуулагдана. Ерөнхий суурийн хичээл зааж буй багш нар өөрийн хичээлээр хэд хэдэн хувилбар бүхий тестүүдийг боловсруулна. СНА явцын болон улирлын шалгалтыг зохион байгуулж, шалгалтын материалыг тестийн машинаар засна.

Улирлын туршид хөндлөнгийн эскпертүүд түүвэр байдлаар ерөнхий суурь хичээлд сууж хичээлийн агуулга, багшийн заах арга зүй, сургалтад тавигдах шаардлагыг хангаж буй талаар үнэлгээ дүгнэлт өгнө.

Ерөнхий суурь хичээлийн явцад оюутны бие даах ажлыг удирдан зөвлөгөө өгөх тогтмол цаг тогтоох бөгөөд хуваарийн дагуу багш, туслах багш нар оюутантай ажиллаж зөвлөгөө өгөх ажлыг улирлын турш зохион байгуулна.

Ерөнхий суурь хичээлийн жагсаалт

2014 оны 07-р сарын 08-ны өдрийн МУИС-ийн Ерөнхий суурийн хичээлийн хороогоор хэлэлцэгдсэн батлагдсан хувилбар

АГУУЛГЫН ЧИГЛЭЛ, БАГЦ ЦАГ	№	Санал болгож буй хичээл	Харьяа сургууль	Харьяалах тэнхим	Түвшин
I. Байгалийн ухаан					
I. Байгалийн ухаан 6 багц цаг	1	<i>Хүрэх үр дүн: Байгалийн юмс үзэгдлийн мөн чанар, шинжлэх ухааны үзэл баримтлалыг ойлгож тайлбарлах, мэдээлэлд шинжлэх ухаанчаар хандах, таамаглал дэвшүүлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадвартай болно.</i>			
	1	Математик 1а	ШУС, БУС	Математикийн тэнхим	Нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухааны чиглэл гэх мэт
	2	Математик 1б	ШУС, БУС	Математикийн тэнхим	Байгалийн ухаан, инженер, бизнесийн ангийн оюутнуудад зориулсан
	3	Математик 1в	ШУС, БУС	Математикийн тэнхим	Байгалийн ухаан, математикийн чиглэлээр сурах сонирхолтой

						оюутнуудад зориулсан	
	4	4	Юмс үзэгдлийн физик үндэс	ШУС, БУС	Физикийн тэнхим	Нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухааны чиглэл гэх мэт	
	5	5	Физик	ШУС, БУС	Физикийн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл	
	6	6	Физикийн үндэс	ШУС, БУС	Физикийн тэнхим	Физикийн мэргэжлээр суралцах оюутнуудад зориулсан	
	7	7	Нийгмийн газарзүй	ШУС, БУС	Газарзүйн тэнхим	Хүмүүнлэг, нийгэм, хууль, эдийн засгийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад	
	8	8	Дэлхий Судлалын Үндэс	ШУС, БУС	Газарзүйн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл	
	9	9	Молекул ба эсийн биологи	ШУС, БУС	Биологийн тэнхим	Хүмүүнлэг, нийгэм, хууль, эдийн засгийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад	
	10	10	Организм ба эволюцийн биологи	ШУС, БУС	Биологийн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл	
	11	11	Экологи ба тогтвортой байдал	ШУС, БУС	Биологийн тэнхим	Нийтлэг	
	12	12	Хими ба амьдрал	ШУС, БУС	Химийн тэнхим	Хүмүүнлэг, нийгэм, хууль, эдийн засгийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад	
	13	13	Байгалийг танин мэдэх химийн үндэс	ШУС, БУС	Химийн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл	
II. Хүмүүнлэгийн ухаан 6 багц цаг	14	II. Хүмүүнлэгийн ухаан <i>Хүрэх үр дүн: Сэтгэлгээний түүхийг танин мэдэх, философи, уран зохиолын бичвэрт дүн шинжилгээ хийх чадвар, урлаг гоо зүйн сэтгэлгээг хөгжүүлэх, ёс зүйн үнэлэмжийг төлөвшүүлэх зорилготой</i>					
		1	Хүний хөгжил, харилцааны ёс зүй (2:1)			Нийтлэг	
		15	2	Эрх зүйн үндэс	ХЗС	Төр, захиргааны эрх зүй, Эрх зүй судлал, Эрүүгийн эрх зүй, Олон улсын эрх зүйн тэнхим	Нийтлэг
		16	3	Хэл шинжлэлийн үндэс	ШУС, ХУС	Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим Европ судлалын тэнхим	Нийтлэг
		17	4	Соёл судлал	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим Ази судлалын тэнхим	Нийтлэг
		18	5	Дэлхийн соёл иргэншил	ШУС, ХУС	Түүхийн тэнхим Ази судлалын тэнхим Европ судлалын тэнхим	Нийтлэг Дэлхийн түүх хичээлтэй уялдуулж сонголттой санал

						болгоно.	
	19	6	Монгол бичиг 1	ШУС, ХУС	Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим	Нийтлэг	
	20	7	Урлагийн боловсрол	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг	
	21	8	Уран зохиолын удиртгал	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг	
	22	9	Шашин судлалын үндэс	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг	
	23	10	Философийн үндэс	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг	
	24	11	Монгол соёл иргэншил	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг	
	25	12	Хүний эрх	ХЗС	ХЗС	Нийтлэг	
	26	11	Олон улсын харилцааны үндэс ба даяаршил	ОУХНУС	-	Нийтлэг	
III. Нийгмийн ухаан 6 багц цаг	27	III. Нийгмийн ухаан					
		<i>Хүрэх үр дүн: Нийгэм эдийн засаг, засаглал, ослын олон талт байдал, хүн хоорондын харилцаа, зан үйлийг танин мэдэх, бүтээлч сэтгэлгээ, шинжлэх ухаанч хандлагад суралцах болно.</i>					
		1	Макроэкономикс ийн үндэс	ШУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг	
		28	2	Микроэкономикс ийн үндэс	ШУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
		29	3	Экономиксын үндэс	ШУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
		30	4	Антропологийн үндэс	ШУС, НУС	Антропологи, археологийн тэнхим	Нийтлэг
		31	5	Археологийн үндэс	ШУС, НУС	Антропологи, археологийн тэнхим	Нийтлэг
		32	6	Социологи	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим	Нийтлэг
		33	7	Нийгмийн ажил	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим	Нийтлэг
		34	8	Улс төр судлалын үндэс	ШУС, НУС	Улс төр судлалын тэнхим	Нийтлэг
		35	9	Сэтгэл судлалын үндэс	ШУС, НУС	Боловсрол, сэтгэл судлалын тэнхим	Нийтлэг
	36		Ардчиллын боловсрол	ШУС НУС	Улс төр судлалын тэнхим	Нийтлэг	
	37	10	Бизнес ба нийгэм	БС		Нийтлэг	
IV. Иргэний боловсрол: БШУЯ-ны шийдвэрийн дагуу Монголын түүх хичээл заавал судлах хичээл юм. 3 багц цаг	38	IV. Иргэний боловсрол					
		<i>Хүрэх үр дүн: Монголын түүх соёл, улс төр, эдийн засаг, эрх зүй, хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, багаар ажиллах үр чадварыг хөгжүүлэх болно.</i>					
		1	Монголын түүх (Ерөнхий)	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг	
		39	2	Монголчууд дэлхийн түүхэнд	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг
		40	3	Монголын түүх: Нүүдэллэхүй ёсон	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг.
	41	4	Монголын түүх:	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг	

		Чингисийн эрин ба Евро-Ази					
	42	5	Монголын түүх: Эзэнт гүрний дараах Монголчуудын түүх соёл	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг	
	43	6	Монгол ба улаан хувьсгал	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг	
	44	6	Монголын түүх: Монголын нийгэм орчин цагийн дүр төрхөд шилжсэн нь	ШУС ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг	
Судалгаа шинжилгээний арга зүй 3 багц цаг	V. Судалгаа шинжилгээний арга зүй 3 багц цаг						
	<i>Хүрэх үр дүн: Тоон болон чанарын мэдээ баримтанд шинжилгээ хийж үнэлэх, логик сэтгэлгээ хөгжүүлэх, шалтгаан ур чадварын холбоог тогтоох, процессийг загварчлах, асуудал тодорхойлж сурна.</i>						
		1	Компьютер тооцооллын үндэс		Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Нийтлэг	
		46	2	Мэдээлэл, харилцаа холбооны технологи	ХШУИС	Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Нийтлэг
		47	3	Мэдээллийн технологийн үндэс	ХШУИС	Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Нийтлэг
		48	4	Магадлал, статистикийн удиртгал	ШУС, БУС ХШУИС	Математикийн тэнхим Хэрэглээний математикийн тэнхим	Нийтлэг
		49	5	Статистикийн үндэс	ШУС, БУС, НУС	Математикийн тэнхим Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
		50	6	Элементар логик ба математик хандлага	ШУС, НУС	Математикийн тэнхим	Нийтлэг
		51	7	Логикийн удиртгал	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг
		52		Хувь хүний санхүү	БС	БС	Нийтлэг
	53	8	Нийгмийн судалгааны аргууд	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим \Эдийн засгийн тэнхим	Нийтлэг	
VI. Яриа бичгийн ур чадвар 3 багц цаг	VI. Яриа бичгийн ур чадвар						
	<i>Хүрэх үр дүн: Яриа бичгийн өөрийгөө илэрхийлэх ур чадвар, эрдэм шинжилгээний бичгийн ур чадвар эзэмших болно.</i>						
		1	Монгол хэл бичиг, найруулга зүй	ШУС, ХУС	Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим	Нийтлэг	
		55	2	Хэл ярианы соёл	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
		56	3	Илтгэх урлаг	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг
	57	4	Академик бичих ур	ШУС, НУС	\Эдийн засгийн тэнхим	Нийтлэг	

		чадвар (монгол, англи хэлээр)		тэнхим, Их британи. Америк судлал		
VII. Англи хэл, бусад хэл 6 цаг цаг	58	VII. Англи хэл, бусад хэл				
		6 цаг цаг				
		<i>Хүрэх үр дүн: Англи хэл бусад хэл -ээр мэргэжлийн эх сурвалжийг ашиглаж чаддаг байх, англи хэлний ярих, сонсох, унших, бичих үр чадварын дундын дээд түвшинг (upper intermediate) хангаж өгнө.</i>				
		1	Ерөнхий англи хэл: Унших дадал (анхан)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	59	2	Англи хэл: Харилцах дадал (анхан)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	60	3	Англи хэл: Бичих дадал (анхан)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	61	4	Академик англи хэл- Унших дадал-1 (Анхан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	62	5	Академик англи хэл- Бичих дадал-1 (Анхан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	63	6	Академик англи хэл: Харилцах дадал-1 (Анхан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	64	7	Академик англи хэл: Бичих дадал-2 (дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	65	8	Академик англи хэл: Унших дадал-2 (дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	66	9	Академик англи хэл: Харилцах дадал-2 (дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	67	10	Академик англи хэл: Унших дадал-3 (ахисан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	68	11	Академик англи хэл: Харилцах дадал-3 (ахисан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	69	12	Академик англи хэл: Бичих дадал-3 (ахисан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	70	13	Ахисан түвшний бичих дадал	ШУС, ХУС	Их Британи Америк судлалын тэнхим	Нийтлэг
	71	14	Ахисан түвшний яриа	ШУС, ХУС	Их Британи Америк судлалын тэнхим	Нийтлэг
	72	15	Солонгос хэл 1	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
	73	16	Солонгос хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
	74	17	Япон хэл 1	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
75	18	Япон хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
76	19	Хятад хэл 1	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
77	20	Хятад хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	

	78	21	Франц хэл 1	ШУС, ХУС	Европ тэнхим	судлалын	Нийтлэг	
	79	22	Франц хэл 2	ШУС, ХУС	Европ тэнхим	судлалын	Нийтлэг	
	80	23	Орос хэл 1	ШУС, ХУС	Европ тэнхим	судлалын	Нийтлэг	
	81	24	Орос хэл 2	ШУС, ХУС	Европ тэнхим	судлалын	Нийтлэг	
	82	25	Герман хэл 1	ШУС, ХУС	Европ тэнхим	судлалын	Нийтлэг	
	83	26	Герман хэл 2	ШУС, ХУС	Европ тэнхим	судлалын	Нийтлэг	
	84	27	Араб хэл	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим		Нийтлэг	
	85	28	Турк хэл	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим		Нийтлэг	
	86	29	Чех хэл	ШУС, ХУС	Европ тэнхим	судлалын	Нийтлэг	
	87	30	Итали хэл	ШУС, ХУС	Европ тэнхим	судлалын	Нийтлэг	
	88	31	Испани хэл	ШУС, ХУС	Европ тэнхим	судлалын	Нийтлэг	
	89	32	Төвд хэл	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим		Нийтлэг	
	90	33	Санскрит хэлний үндэс	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим		Нийтлэг	
VIII. Биеийн тамир, эрүүл ахуй 3 багц цаг	91	VIII. Биеийн тамир, эрүүл ахуй						
		<i>Хүрэх үр дүн: Бие бялдраа хөгжүүлэх, эрүүл амьдрах ухаанд суралцах, эрсдэл гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлж өгнө.</i>						
	1	Биеийн тамир				Биеийн тамирын тэнхим		Нийтлэг
	92	2	Хүнс ба эрүүл хооллолт		ШУС, ШУС		Биологийн тэнхим	Нийтлэг
	93	3	Эмчилгээний биеийн тамир\Тусгай бүлэг				Биеийн тамирын тэнхим	Эрүүл мэндийн байдлаар огцом хөдөлгөөн хийх хязгаартай оюутнуудад
94	4	Эрүүл мэндийн сэтгэл судлал		ШУС, НУС		Боловсрол, сэтгэл судлалын тэнхим	Нийтлэг	

Мэргэжил.

Бакалаврын зэрэг олгох сургалтын төлөвлөгөөний мэргэжил олгох хэсэг нь мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлээс бүрдэнэ.

Оюутны суралцах үндсэн хөтөлбөр\ мэргэжлийн бакалаврын зэргийн тодорхой мэдлэг, чадвар, дадлыг олгох заавал болон сонгон суралцах хичээлүүдтэй байна.

Мэргэжлийн суурь (Бүрэлдэхүүн сургуулийн шаардлага) хичээлийн багц цагт тухайн бүрэлдэхүүн сургууль өөрийн санал болгож буй хөтөлбөр\хөтөлбөрүүдийн шаардлагатай суурь мэдлэг, мэргэжлийн чиглэлийн анхдагч ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээлүүд орно. Мэргэжлийн суурь бүрдэл хэсгийн агуулга, цагийн багтаамжийн талаар бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо санал боловсруулж, Ерөнхий хороонд оруулна. Мэргэжлийн суурь нь ШУС-ийн хувьд байгалийн ухаан, нийгмийн ухаан болон хүмүүнлэгийн ухааны чиглэлээр байж болно.

Оюутан Ерөнхий суурийн хичээлийн 30-аас доошгүй багц цагийг үзэж судалсаны дараа мэргэжлээ сонгоно.

Мэргэжлийн суурь хичээлийн багц цаг нь ШУС-ийн хувьд 9 багц цаг мэргэжлийн сургуулиудын хувьд 21 цаг байна.

Үндсэн мэргэжил олгох багц цагт оюутны суралцах үндсэн чиглэл/хөтөлбөрийн шинжлэх ухаан/мэргэжлийн бакалавр зэргийн тодорхой мэдлэг, чадвар, дадлыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр эзэмшүүлэх зорилготой бүлэг хичээл багтах бөгөөд ШУС-ийн хувьд 60 багц цаг, мэргэжлийн сургуулийн хувьд 54 багц цаг байна. ХЗС-ийн хувьд Нийтлэг шаардлагад заасан нийт багц цагийн багтаамжтай хувь тэнцүүлэн тогтооно.

Үндсэн мэргэжлийн хичээл нь заавал болон сонгон судлах хичээлээс бүрдэнэ. Оюутан үндсэн мэргэжлийн тодорхой салбараар сонгон суралцах боломжтой байх бөгөөд Үндсэн мэргэжлийн сонгох хичээл нь энэхүү зорилгод нийцсэн, оюутан сонгох боломжоор хангагдсан байна.

Чөлөөт сонголт

Чөлөөт сонголтын зорилго нь оюутан МУИС-д зааж байгаа бүх хичээлээс өөрийн хүсэл, сонирхлын дагуу чөлөөтэй сонгох боломжийг олгоход оршино. Чөлөөт сонголтын багц цаг нь 15 багц цагаас багагүй байх бөгөөд оюутан энэ цагийг үндсэн мэргэжлийн хүрээнд мэргэших, хавсарга болон хос мэргэжил эзэмших, их сургуулийн хэмжээнд хүссэн хичээлээ сонгон үзэхэд зориулна.

Хавсарга мэргэжил

Хавсарга мэргэжил нь оюутны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд давуу боломжтой оролцох нөхцлийг бүрдүүлэхэд чиглэх бөгөөд нийт 30 багц цагаас илүүгүй байх бөгөөд үндсэн мэргэжлийн зэрэгцээ хавсарга мэргэжил эзэмших оюутны нийт багц цагийн хэмжээ 130 багц цагаас багагүй байна.

Хос мэргэжил

Суралцаж буй чиглэлээсээ өөр мэргэжлээр давхар суралцах тохиолдолд хөтөлбөрийг санал болгож байгаа мэргэжлийн тэнхим залгамж хэлбэрээр болон зэрэгцүүлэн судлавал зохих хичээл, суралцсан хугацааны голч дүнгийн босго зэрэг холбогдох дүрэм, журамд нийцсэн тусгай шаардлагуудыг сургалтын төлөвлөгөөнд тодорхой тусгасан байна.

Суралцагч эзэмшихээр суралцаж буй үндсэн мэргэжлийнхээ сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийг бүрэн судалж, мэргэжлийн хичээлийн багц цагийн 1/3-ийг амжилттай цуглуулсан, суралцсан хугацааны голч дүн 3.2-оос дээш байх нийтлэг шаардлагыг хангахаас гадна мэргэжлийн тэнхимээс тавьсан бусад тусгай шаардлагыг хангасан тохиолдолд хос мэргэжлээр суралцах хүсэлт гаргаж болно.

Хос мэргэжлээр суралцах эрхийг бүрэлдэхүүн сургуулиудын зөвшөөрлийг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар сургалтын хэлбэрийг (өдөр, орой, эчнээ) тодорхой зааж баталгаажуулна.

МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР

МУИС-ийн хэмжээнд БШУЯ-наас баталсан өгсөн 93 магистрын зэрэг олгох хөтөлбөрөөр сургалт явуулж байна. Магистрын сургалтын төлөвлөгөө 32 багц цаг байна. Магистрантурын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүд судалгааны арга зүй 2 багц цаг, англи хэл 2 багц цаг, мэргэжлийн хичээлүүд 9 багц цаг, мэргэших хичээл 9 багц цаг, эрдэм шинжилгээний ажил 4 багц цаг, магистрын ажил 6 багц цаг гэсэн бүтэцтэй.

Өдрөөр суралцагч нэг улиралд 12, эчнээгээр суралцагч 9-өөс ихгүй багц цагийн хичээл судална. Магистрын сургалтын ердийн хугацаа 2 жил, салбар болон мэргэжил дундын магистрын сургалтын ердийн хугацаа 2-2.5 жил. Судалгааны ажлыг тасралтгүй хийж, чанартай үр дүн гаргаж, багц цагаа бүрэн биелүүлсэн бол удирдагч, тэнхим, бүрэлдэхүүний сургууль, СНА-ны зөвшөөрлөөр магистрын сургалтын хугацааг хагас жилээр богиносгож болно. Мэргэжил өөрчилж суралцахтай холбоотойгоор судлах бэлтгэл сургалтын хугацааг судлах багц цагийн хэмжээнээс хамааруулж бүрэлдэхүүн сургуулийн захирлын шийдвэрээр тогтооно. Энэ хугацаа 2 улирлаас ихгүй байна.

Судалгааны арга зүй хичээлээр оюутан тухайн шинжлэх ухааны салбарын судалгааны аргууд, туршилтын үр дүнг боловсруулах, мэдээлэл хайх, боловсруулах, загварчлах, тоо баримт цуглуулах, компьютерээр боловсруулалт хийх, тооцоолох, монограф (нэг сэдэвт зохиол), өгүүлэл судлах, илтгэл тавих, өгүүлэл хэрхэн бичих талаар мэдлэг, дадлага олж авна. Мэргэжлийн заавал үзэх хичээлээр оюутан шинжлэх ухааны тухайн салбараар судлаач хүний эзэмшсэн байх ёстой мэдлэгийг, мэргэших хичээлээр нарийн мэргэжлээр эзэмшсэн байх ёстой мэдлэг, үр чадварыг олж авах юм.

Магистрын түвшний оюутан болгон эрдэм шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Магистрантын эрдэм шинжилгээний багц цагийг эрдэм шинжилгээний төлөвлөгөөт семинар, их семинарт оролцсон, туршилт судалгаа хийсэн, судалгааны ажлын үр дүнг эрдэм шинжилгээний семинар, их сургууль, дотоод, гадаадын эрдэм шинжилгээний хуралд илтгэж хэлэлцүүлсэн, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн зэргээр удирдагч үнэлж, тэнхим/профессорын баг баталгаажуулна. Магистрын ажлын багц цагийг магистрантын бичсэн магистрын ажил шаардлагыг бүрэн хангасан гэж удирдагч багш үзсэн тохиолдолд тухайн сургуулийн СНА СиСи системд тооцож оруулна. Сургууль болгоны хувьд магистрант оюутнуудын эрдэм шинжилгээний ажлын багц цагийг хэрхэн тооцох талаар <http://graduate.num.edu.mn/> хаягаар орж үзнэ үү.

Элсэж орсон эхний улиралд магистрант оюутнууд судлах хичээлийн багц цагийг улирлаар сонгож багцалсан, магистрын ажлын сэдэв, удирдагч багшаа сонгож тодорхойлсон сургалтын ганцаарчилсан төлөвлөгөөг хийнэ. Магистрын ажлын сэдэв, удирдагч багшаа сонгоход мэргэжлийн тэнхим, профессорын баг, профессор, оюутны саналд тулгуурладаг. Уг ганцаарчилсан төлөвлөгөөг хийхэд тухайн сургуулийн СА-ны зааварлагч туслах бөгөөд оюутан зохих хүснэгтийн дагуу хийж, гарын үсгээ зурж баталгаажуулан сургуулийн СНА-ны сургалт хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. Энэхүү хүлээлгэн өгсөн ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу тухайн сургуулийн СНА магистрын ажлын сэдэв, удирдагчийг томилсон тушаал төлөвлөн, МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулдаг. Магистрант, докторант оюутан хүндэтгэх шалтгаанаар удирдагч, сэдвээ өөрчлөх хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, профессорийн саналыг үндэслэн тухайн сургуулийн СНА-ны дарга шийдвэрлэнэ.

ДОКТОРЫН ХӨТӨЛБӨР

МУИС-ийн хэмжээнд БШУЯ-наас баталж өгсөн 44 докторын зэрэг олгох хөтөлбөрөөр сургалт явуулж байна. Докторын сургалтын төлөвлөгөө нь мэргэжлийн хичээл 12 багц цаг, мэргэших хичээл 18 багц цаг, эрдэм шинжилгээний ажил 18 багц цаг, диссертаци 12 багц цаг, нийт 60 багц цагийн бүтэцтэй байна. Өөрөөр хэлбэл, танхимд үзэх хичээлийн багц цаг 30, судалгааны ажлын нийт багц цаг 30 байна.

Докторын сургалтын ердийн хугацаа өдрөөр суралцахад 3 жил, эчнээгээр суралцахад 4 жил, экстернат бол 1-2 жил байна. Өдрөөр суралцагч нэг улиралд 12, эчнээгээр суралцагч 9-өөс ихгүй багц цагийн хичээл судална. Эрдэм шинжилгээний багц цагийн гүйцэтгэлд хязгаар тогтоодоггүй. Өөрөөр хэлбэл эрдэм шинжилгээний 18 багц цагийн ажлыг аль ч улиралд гүйцэтгэж, цуглуулж болно гэсэн үг.

Элсэж орсон эхний жилд доктор оюутнууд судлах хичээлийн багц цагийг улирлаар сонгосон, диссертацийн ажлын сэдэв, удирдагчийг сонгож тодорхойлсон сургалтын ганцаарчилсан төлөвлөгөөг хийнэ. Докторын диссертацийн сэдэв, удирдагч сонгох нь хамгийн чухал сонголт байдаг. Тиймээс элсэн орсон эхний жилдээ мэргэжлийн тэнхим, профессорын баг, профессоруудтай зөвлөлдөн өөрийн саналд тулгуурлан сонгох хэрэгтэй. Сургалтын ганцаарчилсан төлөвлөгөөг хийхэд тухайн сургуулийн СА-ны зааварлагч туслах бөгөөд оюутан зохих хүснэгтийн дагуу хийж, гарын үсгээ зурж баталгаажуулан сургуулийн СНА-ны сургалт хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. Энэхүү хүлээлгэн өгсөн ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу тухайн сургуулийн СНА докторын диссертацийн сэдэв, удирдагчийг томилсон тушаал төлөвлөн, МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулдаг. Докторант оюутан хүндэтгэх шалтгаанаар удирдагч, сэдвээ өөрчлөх

хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, профессоруудын саналыг үндэслэн, бүрэлдэхүүн сургуулийн СНА шийдвэрлэнэ.


Экстернат хэлбэрээр суралцах докторантын мэргэших хичээлийн 18 хүртлэх багц цагийг бүтээлүүдээр нь дүйцүүлэн тооцож болно. Дүйцүүлэн тооцож болох цагийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын томилсон комисс үнэлж, бүрэлдэхүүн сургуулийн СНА-ны дарга баталгаажуулна. Дүйцүүлэн тооцож болох бүтээлд:

- 1) Үр дүн нь диссертацийн ажилд орохгүй, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл,
- 2) Их сургуулийн сурах бичиг
- 3) Хэвлүүлсэн монографи,
- 4) Зохион бүтээсэн багаж төхөөрөмж, тогтоосон стандарт,
- 5) Байгуулсан эрдэм шинжилгээний лаборатори, эрдэм шинжилгээний музей,
- 6) Зарим боловсруулалтууд (компьютерийн программ, газрын зураг/карт, хуулийн төсөл, албан ёсоор улсын хэмжээнд мөрдөж буй аргачлал, стандарт г.м) зэрэг бүтээлүүд орно.

Докторантын эрдэм шинжилгээний 18 багц цагийг тооцохдоо эрдэм шинжилгээний төлөвлөгөөт семинар, их семинарт бүрэн суусан бол 0.1 багц цаг, өөрийн судалгааны ажлаа эрдэм шинжилгээний семинарт илтгэсэн бол 0.2 багц цаг, улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн бол 0.5 багц цаг, олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн бол 1.0 багц цаг, профессорын зөвлөлөөр зөвшөөрөгдсөн дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бол 3.0 багц цаг, гадаадын нэр хүндтэй их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бол 3.5 багц цаг, хянан магадлагаа бүхий гадаадын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн бол 5.0 багц цаг биелүүлдэнд тооцдог. Ном, гарын авлага, сурах бичгээр багц цаг тооцдоггүй.



III БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ХУАНЛИ

2014-2015 оны хичээлийн жилийн намрын улирал



Тэмдэглэл

2014-2015 оны хичээлийн жилийн хаврын улирал




Тэмдэглэл

СИСИ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

СиСи систем нь МУИС-ийн сургалт үйл ажиллагаанд хэрэглэдэг систем юм. Энэхүү системийн зорилго нь МУИС-ийн сургалт, удирдлага, зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааг хөнгөвчлөх, чанаржуулах, шуурхай, найдвартай, ил тод, хяналттай болгох явдал юм. Энэхүү системийг МУИС-ийн салбар сургуулиудын багш ажилтан, оюутан болон удирдлагууд хэрэглэх ба систем нь МУИС-ийн хүрээнд хэрэглэгддэг системүүд болон бусад гадны системүүдтэй хамтарч ажиллана.

СиСи систем нь вэбд суурилсан, монгол ба англи хэл дээр ашиглах боломжтой бөгөөд диплом, дипломын хавсралтыг англи, кирилл, монгол бичгээр хэвлэхтэй холбоотойгоор монгол бичгийг дэмжинэ.

Элсэлтээс төгсөлт хүртэлх сургалтын бүхий л үйл ажилгаа уг системээр дамжиж явагдана.



1. ТУСЛАМЖ

1.1 Нэвтрэх эрх авах

SiSi системийн хэрэглэгч бүр системд **нэвтрэх нэр, нууц үгтэй** байх ба нэвтрэх нэр МУИС-ийн хэмжээнд давтагдахгүй оюутны хувийн дугаар байна.



Оюутан та нэвтрэх нэр буюу хувийн дугаараа өөрийн сургуулийн сургалтын албаны ажилтнаас авна уу.

Оюутны дугаар нь элссэн он, суралцаж буй түвшин, төрөл, салбар сургууль гэх мэт мэдээллийг агуулдаг. Жишээ нь: Оюутны дугаар 10B1LAW0000 бол

- 10 - 2010 оны элсэлт
- B - Бакалавр
- 1 - Өдрийн анги
- LAW- Хууль зүйн сургууль
- 0000 - давтагдахгүй дугааргэх мэт.

Нэвтрэх нууц үг нь оюутны төрсөн он сар өдрөөр үүсдэг. Жишээ нь: 1990 оны 1-р сарын 1нд төрсөн бол таны нууц үг 19900101 гэж үүсэх болно.



Хэрэв та системд нэвтэрч чадахгүй бол төрсөн он сар өдрийн мэдээлэл системд зөв бүртгэгдсэн эсэхийг сургалтын албаны ажилтан хандаж шалгуулна уу.

1.2 Нууц үг солих

Нууц үгээ солихдоо СиСи нүүр хуудасны дээд хэсэгт байрлах тохиргооны цэснээс **Нууц үг солих** цэсийг сонгоно уу. Гарч ирэх хэсэгт өөрийн хуучин нууц үг болон шинэ нууц үгээ оруулан **Өөрчлөх** товчин дээр дарна.

ym EN/MN Гэрэл ▾

- Хувийн мэдээлэл
- Хувийн мэдээлэл засварлах
- Хамгаалалт
- Нууц үг солих**
- Хамгаалалт
- Гарах

Нууц үг
солих



Нууц үг өөрчлөх

Хуучин нууц үг

Шинэ нууц үг

Шинэ нууц үг давт

Өөрчлөх

1.3 Нууц үг мартсан бол

Нэвтрэх хэсэгт байрлах холбоосыг ашиглаж системд бүртгүүлсэн майл хаягаараа шинэ нууц үг авах боломжтой.

Мэдээллийн систем SISI 4.0

Нууц үг / Password

Дээрх кодыг оруулна уу / Enter code

Нууц үгээ мартсан уу? / Forgot Password?

Нэвтрэх / Sign in

Нууц үг
сэргээх



Хэрэглэгчийн нэр:

E-mail хаяг:

Илгээх

Үүний тулд та э-майл хаягаа анх оюутан болж системд бүртгүүлэхдээ зөв бүртгүүлсэн байх хэрэгтэй. Мөн сургалтын албаны ажилтандаа хандаж мэдээллээ өөрчлүүлэх, мөн өөрийн хувийн мэдээлэл засварлах хэсгээр өөрчилж болно. Мөн та нууц үгээ мартсан бол сургалтын албаны ажилтандаа хандаж нууц үгээ солиулж авах боломжтой.

1.4 Хэл сонгох

СиСи системийг Монгол, Англи хэл дээр ашиглах боломжтой. СиСи нүүр хуудасны дээр байрлах **EN/MN** холбоосоор хэлээ солих бөгөөд ингэснээр оюутан та дүнгийн тодорхойлолт, хичээлийн мэдээллийг Монгол, Англи хэлээр авах боломжтой.


2. ЕРӨНХИЙ

2.1 Дүнгийн мэдээлэл үзэх


Дүнгийн мэдээлэл нь оюутны сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлсон баримт байна.

Оюутан та өөрийн эрхийн үндсэн цэсний **Дүнгийн мэдээлэл** хэсгээс нийт болон тодорхой улирал хооронд суралцсан хугацааны дүнгийн мэдээллийг харах болон хэвлэх боломжтой. Тодорхой улирал хоорондох дүнгийн мэдээллээ харах болон хэвлэхдээ хичээлийн жил болон улирлаа оруулан харгалзах товчин дээр дарснаар дүнгийн мэдээлэл гарч ирэх болно.

Дүнгийн мэдээлэл



Хичээлийн жил
2012
Намрын улирал
2012
Намрын улирал
>>



Монгол Улсын Их Сургууль
Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль

2012 оны 9 сарын 1 -ны өдрийн 449 тоот тушаалаар "Электроник, автоматик" (Бакалавр, Өдрийн сургалт) хөтөлбөрт элсэн орсон **Овог овогтой Нэр** -ын дүнгийн мэдээлэл

ИНДЕКС	ХИЧЭЭЛ	БЦ	ОНОО	ДҮН	ИНДЕКС	ХИЧЭЭЛ	БЦ	ОНОО	ДҮН
2012	ENGL100 Англи хэл-1	3	83	B-	2013 Хавар	ENGL100 Англи хэл-2	3	92	A-
Намар	SPRT100 Биеийн тамир I	1.5	100	A		SPRT100 Биеийн тамир II	1.5	97	A
	FNDP100 Гамшигаас хамгаалах менежментийн үндэс	1	90	A-		EMAT200 Дифференциал тэгшитгэл	4	100	A
	EPHY101 Механик ба молекулын физик	3	92	A-		ELEC105 Мэргэжлийн дадлага	1	96	A
	COMP100 Мэдээллийн технологи, мэдээллийн систем	3	80	B-		EPHY201 Оптик, квант физик	3	96	A
	ALGE101 Шугаман алгебры, Вектор анализ (Инженерийн математик-1)	4	88	B		CSSW101 Програмчлалын үндэс	3	78	C
	ELEC101 Электроникийн үндэс	3	82	B-		EPHY102 Цахилгаан ба соронзон	3	86	B
		18.5		86.6			18.5		91.8
				Улирлын голч дүн					3.5

Судалсан багц : **70.0** Голч оноо :

Цуглуулсан багц цаг : **67.0** Голч дүн :

Сургалтын алба

Таны тухайн улиралд судалж буй хичээлийн дүнг багш шалгалтын хугацаанд системд оруулснаар таны дүнгийн мэдээлэлд орж ирнэ. Хэрвээ багш таны дүнг буруу оруулсан тохиолдолд шалгалтын хугацаанд засах боломжтой. Хэрвээ шалгалтын хугацаа дууссан тохиолдолд багш таны дүнг засвал энэ нь засварлагдсан дүн болох бөгөөд энэ дүнг СА-ны эрхлэгч зөвшөөрсөн тохиолдолд таны жинхэнэ дүн болно.



Шалгалтын хугацаа гэдэг нь хичээлийн эцсийн шалгалтыг авах хугацаа юм. Багш энэ хугацаанаас эхлэн ажлын 5 хоногт дүн оруулах, засварлах эрхтэй.

2.2 Хичээлийн хуваарь

Оюутан та өөрийн эрхийн үндсэн цэсний **Хуваарь -> Хичээлийн** хэсэг мөн үндсэн нүүрний дээд хэсэгт байрлах **Хичээлийн хуваарь** хэсгээс өөрийн хичээлийн хуваарийг тухайн нэг өдрөөр болон 7 хоногоор харахаас гадна МУИС-ийн салбар сургууль тус бүрийн бүх түвшний хичээлийн хуваарийг хичээл, багш болон өрөө хэлбэрээр харах боломжтой. Мөн энэ хэсгээс тухайн хичээлийг орж байгаа багшийн мэдээлэл, өрөөний мэдээлэл болон хичээлийн мэдээллийг харах боломжтой юм.

Өөрийн хичээлийн хуваарийг харахдаа хугацаагаа сонгон **Өөрийн хуваарь** хэсгийг сонгох ба 7 хоногоор харах бол **7 хоногоор** хэсгийг сонгоно. МУИС-ийн салбар сургуулиудын хичээлийн хуваарийг харахдаа салбар сургуулиа сонгон хичээл, багш болон өрөө хэлбэрүүдийн аль хэлбэрээр харахаа зааж өгнө.

Нэрс	9:0	9:45	10:40	11:25	12:20	13:5	14:0	14:45	15:40	16:25	17:20	18:5	19:0	19:45	20:40	21:25	22:20	23:5
Объект хандлагат програмчлал	115	Хичээлийн байр	3А															
		Өсөхбаатар_Д																

2.3 Шалгалтын хуваарь

Шалгалтын хуваарь нь оюутан таны тухайн улиралд судалж буй хичээлийн эцсийн шалгалтыг авах хуваарь бөгөөд энэ хуваарийг салбар сургалтын албанаас оруулж өгнө. Шалгалтын хуваарийг системээр хийснээр оюутан таны судалж буй хичээлүүдийн эцсийн шалгалт давхцах асуудал гарахгүй бөгөөд өөрийн шалгалтын хуваарийг системээс хялбараар харах боломжтой юм. Оюутан та өөрийн эрхийн үндсэн цэсний **Хуваарь-> Шалгалтын** хэсгээс өөрийн шалгалтын хуваарийг харах боломжтой.

Хуваарь ▾

Хичээлийн

Шалгалтын

"2014 оны хичээлийн жилийн хаврын улирал"
-ын шалгалтын хуваарь

Огноо	Хичээл	Цаг	Өрөө	Шалгалт авах багш	Тайлбар
2014/05/29	Телехолбооны үндэс ITCM351-3.0 кр	14:00 - 15:30	Хичээлийн байр 3А - 114	Бямбажав, Дор. Доржжамц, Миж. Золбоо, Бям.	
2014/05/30	Объект хандлагат програмчлал CSSW223-3.0 кр	10:00 - 12:00	Хичээлийн байр 3А - 116 Хичээлийн байр 3А - 114	Гантулга, Гом. Пүрэв, Жай. Өсөхбаатар, Дот.	

Санамж: Хэрэв таны судалж буй зарим хичээлийн шалгалтын хуваарь жагсаалтанд байхгүй бол СА-наас лавлах буюу СА-ны мэдээллийн самбараас харж нягтална уу!

2.4 Багш ажилчдын мэдээлэл

Оюутан та өөрийн эрхийн үндсэн цэсний **Багш ажилчид** хэсгээс МУИС-ийн бүх багш, ажилчдын мэдээллийг харах боломжтой. Та МУИС-ийн бүрэлдэхүүн нэгжээс сонгоход тухайн нэгжийн багш, ажилчид гарч ирэх бөгөөд дэлгэрэнгүй танилцуулгатай танилцаж болно.

2.5 Сургалтын төлөвлөгөө

Оюутан та сурч буй сургалтын төлөвлөгөөгөө үндсэн цэсний **Сургалтын төлөвлөгөө** хэсгээс харах болон хянах боломжтой. Энэ хэсэгт эхлээд сургалтын төлөвлөгөөний бүлгүүд гарч ирэх ба тухайн бүлэг дээр дарснаар хичээлүүд гарч ирнэ. Та тухайн төлөвлөгөөнөөс ямар ямар хичээлийг судалсан болон судлаагүй, заавал болон сонгон судлах хичээлүүдээс нийт хэдэн багц цаг судалсан талаарх мэдээллээ харах боломжтой.

Сургалтын төлөвлөгөө

ТАНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


#	Хичээлийн индекс	Багц цаг	Хичээлийн нэр	Төлөв
Бакалаврын судалгааны ажил - (3 БАГЦ ЦАГ)				
1	ТНЕС400	3	Бакалаврын судалгааны ажил	Судлаагүй
	Нийт	3 бц		
	Судалсан багц цаг	0 бц		

2.6 Оюутны цахим үнэмлэх

Оюутан та салбар сургуулийн сургалтын албаны ажилтандаа хувийн болон элсэлтийн мэдээлэл, цээж зургаа өгсөнөөр сургалтын албаны ажилтан таны мэдээлэл, зургийг системд бүртгэж оюутны үнэмлэхийг захиална. Цахим үнэмлэх бүр дахин давтагдахгүй нууц дугаартай байх бөгөөд таны үнэмлэхний дугаар системд нэвтрэх хэрэглэгчийн нэр байна. Таны цахим үнэмлэх хэвлэгдэн, бүртгэгдсэн бол системээс мэдэгдэх бөгөөд та сургуулийнхаа сургалтын албаны ажилтнаас аваарай. Та үндсэн цэсний **Оюутны цахим үнэмлэх** хэсгээс цахим үнэмлэх хэвлэгдсэн эсэх мөн бусад шаардлагатай мэдээллийг авах болно.

2.7 OCW нээлттэй хичээл

OCW нь Open Course Ware үгний товчлол бөгөөд оюутан та МУИС-ийн бүх багш нарын үүсгэсэн нээлттэй хичээлийг эндээс үзэх боломжтой юм. OCW нээлттэй хичээлийг үзэхдээ <http://sisi.num.edu.mn/ocw> хаягаар эсвэл системийн нүүр хуудасны дээд хэсэгт байрлах **OCW** хэсгийг сонгох ба энэ нь OCW нээлттэй хичээлийг үзэх хэсэг рүү үсрэх болно. Гарч ирэх хэсгээс аль сургуулийн аль тэнхмийн ямар хичээлийг үзэх гэж байгаагаа сонгоно.



2.8 Онлайн тестийн систем

Оюутан та тухайн улиралд судалж буй хичээлийн шалгалтыг онлайнар тест хэлбэрээр өгөх боломжтой. Онлайнар авах шалгалтын асуулт, хариулт, шалгалт авах хугацаа гэх мэт тестэнд шаардлагатай өгөгдлүүдийг тухайн хичээлийг зааж буй багш оруулж өгөх бөгөөд оюутан та <https://sisi.num.edu.mn/test> хаягаар тестийн систем рүү өөрийн СиСи эрхээр нэвтрэн орно. Та системд нэвтэрснээр таны шалтгалт өгөх хичээлийн харалдаа **Шалгалт өгөх** товч идэвхжсэн байх бөгөөд энэ товчин дээр дарснаар тестийн шалгалт эхлэх болно. Оюутан таны оноо шалгалтын хугацаа дуусахад шууд бодогдон гарах болно.

Энэ улиралд байгаа шалгалтууд				
Шалгалт	Хичээлийн нэр	Эхлэх	Дуусах	Оноо
14.00-2013 намар Явц	Өгөгдөл дасжуулах үндэс	2013-11- 08T14:19:00	2013-11- 08T14:32:00	5
2014.04.10- 11tsag	Компьютерийн сүлжээ	2014-04- 10T11:50:00	2014-04- 10T12:23:00	0
2014.4.10- 14tsag	Компьютерийн сүлжээ	2014-04- 10T15:07:00	2014-04- 10T15:40:00	<input type="button" value="Шалгалт өгөх"/>

3. ХИЧЭЭЛ БҮРТГҮҮЛЭЛТ

МУИС-ын оюутан улирал бүр өөрийн үзэх хичээлд бүртгүүлэх ёстой. Хичээлд бүртгүүлэлт 2 үе шаттай явагддаг


✓ **Санал.** Оюутан хичээлийн улирлын 13, 14 дэх долоо хоногт багтаан, дараагийн улиралд заавал судлахаас гадна сонгож судлах хичээлд санал өгнө.

✓ **Баталгаажуулалт.** Ирэх улиралд орох хичээл, анги танхим, цаг, багшийн талаарх мэдээлэл бүхий хичээлийн ерөнхий хуваарийг салбар сургалтын алба бэлэн болгосны дараа журамд заасан хугацаанд оюутан хичээлийн хуваариудаас сонгож бүртгүүлэн сургалтын төлбөр төлж баталгаажуулна.


3.1 Хичээлд бүртгүүлэлт санал:

Хичээлд бүртгүүлэлтийн саналын үе нь оюутан дараагийн улиралд өөрийн сургалтын төлөвлөгөөн дэх үзээгүй хичээлүүдээс ямар хичээлийг үзэх хүсэлтэй байгааг тодруулах зорилготой. Оюутнуудын саналыг үндэслэн тэнхим сургалтын алба дараагийн улиралд ямар хичээлийг аль багш хичнээн заах мөн хичнээн оюутан суралцахыг тодорхойлж дараагийн улирлын хичээлийн хуваарийг боловсруулдаг.

Саналыг сургалтын нэгдсэн албанаас нээсэн тохиолдолд таны нүүр хуудсанд багшийн санал асуулгад оролцох товч идэвхжинэ. Тухайн улиралд судалсан бүх хичээлийн багшийн санал асуулгад оролцсоны дараа дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх болно.



Тухайн улиралд судалж буй бүх хичээлийнхээ багшийн санал асуулгад оролцсоны дараа нүүр хуудасны Мэдээ хэсэг болон үндсэн цэсний Хичээлд бүртгүүлэх -> Санал хэсэгт дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх эрх нээгдэнэ.



Санал өгөх хэсэгт таны сурч буй төлөвлөгөөний бүх хичээлүүд санал өгөх боломжтой, боломжгүй тайлбарын хамт гарч ирнэ. Тухайн хичээлийн урд ногоон таван хошуу байвал та тэр хичээл санал өгөх боломжтой.

Ногоон таван хошуун дээр дарахад дараах асуулт гарч ирэх бөгөөд санал өгөх бол **OK** товчин дээр үгүй бол **Cancel** товчин дээр дарна.

Санал өгсөн хичээл дараах байдалтай харагдах бөгөөд саналыг цуцлахаар бол Цуцлах товчин дээр дарна.

Судалсан эсвэл судалж байгаа

Сонгох боломжтой

Судлах боломжгүй

А. ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛ

★	SPRT101	36ц	Биеийн тамир
★	HIST101	36ц	Монголын түүх
★	FNDP100	06ц	Гамшигаас хамгаалах менежментийн үндэс
★	PENG200	26ц	Мэргэжлийн англи хэл
★	ENGL100	26ц	Англи хэл I
★	ENGL100	26ц	Англи хэл II
цуцлах	ENGL100	26ц	Англи хэл 3

Сонгосон багш:

3.2 Хичээлд бүртгүүлэлт баталгаажуулалт:

Бакалаврын Сургалтын Албанаас хичээлд бүртгүүлэлт (Баталгаажуулалт) нээсэн тохиолдолд оюутан та эрхээрээ нэвтрэн ороход дараах хэсэг гарч ирэх болно. **Энд дарж орно уу** гэсэн хэсэг дээр дарахад хичээл сонгох хэсэг гарч ирнэ.

Мэдээ 1 сарын 17

Хичээлд бүртгүүлэх
МУИС, МТС-ийн хичээлд бүртгүүлэлт
(Баталгаажуулах) 2014/1/16 15:50 - 2014/1/16 23:59 хооронд явагдана. **Энд дарж орно уу!**

Хичээл сонгох хэсэг рүү хандах хэсэг

Үндсэн мэдээлэлтэй танилцах

Оюутан таны сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээлүүд доорх тэмдэглэгээний хамт гарч ирэх бөгөөд тус бүр утга илэрхийлнэ.

- ✓ Баталгаажуулсан хичээл
- ★ Судлах боломжтой
- ★ Судлах боломжтой боловч хичээлийн хуваарь бэлэн биш
- ★ Судлах боломжтой боловч хичээлийн хуваарьт тавигдаагүй
- ★ Судалсан эсвэл судалж байгаа
- ★ Судлах боломжгүй
- ★ Судлах боломжгүй хичээл сонгосон
- ★ Хичээлд санал өгөөгүй, хичээл сонголтын үргэлжлэх хугацааны 1/2-с хойш сонгох боломжтой.

Тухайн хичээлүүдийн төлөв буюу тэмдэглэгээ. Эндээс цэнхэр таван хошуу буюу Судлах боломжтой боловч хичээлийн хуваарьт тавигдаагүй байвал Сургалтын Албандаа хандана уу!!!

Оюутан танд тус болохуйц мэдээллүүд дараах байдлаар харагдах болно.

Үндсэн мэдээлэл

Нийт судалсан кредит: 54

Нийт судалсан кредит

Туслах мэдээлэл

Максимум кредит: 21
Нэг кредитийн төлбөр: 17
Суралцаж буй түвшин: 2

Тухайн улиралд суралцах кредитийн дээд хязгаар кр-ийн төлбөр Суралцаж байгаа түвшин

Баталгаажаагүй кредитийн мэдээлэл

Нийт сонгосон кредит: 0
Кредитийн төлбөр: 0.00₮
Суурь хураамж: 1000000₮
Нийт төлбөр: 1000000.00₮

Сонгосон кредитийн мэдээлэл болон төлбөл зохих төлбөрийн мэдээлэл

Баталгаажсан кредитийн мэдээлэл

Нийт сонгосон кредит: 0
Кредитийн төлбөр: 0.00₮
Суурь хураамж: 0₮
Нийт төлбөр: 0.00₮
Таны дансны үлдэгдэл: 0.00₮

Баталгаажсан кредит болон

СиСи дансны үлдэгдэл


Таны суралцаж буй түвшин судалсан кредитээс хамаарна.

Судалсан кредит	Түвшин
0-30	1
31-60	2
61-90	3
90-с их	4


Оюутан хэдэн кр цуглуулснаас хамаарч суралцаж буй түвшин тодорхойлогдоно.

Хуваарь сонгох

Үндсэн мэдээлэлтэй сайтар танилцсаны дараа өөрийн судлах хичээлийн хуваарийг зохионо. Сонгох боломжтой хичээлүүд дээр дурдсаны адил урдаа ногоон таван хошуутай харагдах бөгөөд хичээл бүрийн үрд байгаа тэмдэглэгээн дээр заагчаа / хулгана / аваачихад тэмдэглэгээний тайлбар гарч ирнэ.




Сонгох боломжтой хичээл буюу ногоон таван хошуу дээр дарахад тухайн хичээлийн сонгох боломжтой хуваариуд гарч ирнэ.



Лекцийг сонгоход лаборатори эсвэл семинар автоматаар гарч ирэх / хэрвээ лекц байхгүй бол лаборатори эсвэл семинарыг сонгоно / ба хуваариудаа бүрэн сонгосны дараа **Сонгох** товчийг даран хуваариа сонгоно. Мөн семинарыг дарахад лаборатори гарч ирэх ч тохиолдол бий.

Амжилттай сонгосон хичээл хуваарийн хамт дараах байдлаар харагдах ба **Цуцлах** товчийг даран хуваарийг цуцалж болно.



Хичээл баталгаажуулах

МУИС-ийн сургалтын систем нь банкны онлайн төлбөр тооцооны системтэй холбогдсон бөгөөд тус сургуулийн оюутнууд сургалтын төлбөрөө онлайн гүйлгээний эрхтэй, дотоодын картаар төлөх болно.

Хичээл сонголтыг баталгаажуулсанаар та тухайн хичээлд албан ёсоор бүртгэгдэх ба баталгаажуулахын тулд тухайн улиралд судлах кредитийн төлбөр болон суурь хураамж заавал төлөх болно.



Хичээл баталгаажуулсаны дараа хичээлийг цуцлах бол нэмэлт төлбөр төлөх болохыг анхааран **сонголтоо харууцлагатай хийгээрэй.**

Баталгаажуулах

Баталгаажуулалт нь банкны системтэй холбогдсон бөгөөд багцын төлбөрийг онлайн хэлбэрээр төлөх болно.

Сонгосон кредит болон төлбөрийн мэдээлэл	
Нийт кредит:	2.00
Нэг кредитийн төлбөр:	<input type="text"/>
Нийт кредитийн төлбөр:	<input type="text"/>
Суурь хураамж:	100000
Хоцорсон бүртгэлийн төлбөр:	0
Төлбөл захих:	<input type="text"/>
Дансны үлдэгдэл	0.00

Төлбөр төлснөөр таны сонгосон хичээлүүд баталгаажих болно.

[Хаан банкаар](#) [Голомт банкаар](#)

МУИС-ийн оюутан хичээл сонголт хийсний дараа сонгосон кредит цаг болон суурь хураамжийг нэхэмжилсэн хуудас банкны системд очих бөгөөд төлбөрөө төлөхдөө тухайн банкны гүйлгээний эрхтэй карт хэрэглэнэ.

Таны SISI-гийн дансанд байрлах илүү болон дутуу төлөлт одоогийн хичээл сонголтын төлбөрт тооцогдоно. (Жишээ нь: Таны дансанд 200'000 төгрөгний илүү төлөлт байгаа бөгөөд та 500'000 төгрөгний хичээл сонгож байгаа тохиолдолд та 300'000 төгрөг төлнө. Эсвэл та 200'000 төгрөгний дутуу төлөлтэй бол та 700'000 төгрөг төлнө.) SISI дэх дансны үлдэгдлийг баталгаажсан кредитийн мэдээлэл хэсгээс харна уу.

Баталгаажсан кредитийн мэдээлэл

Нийт сонгосон кредит: 0
Кредитийн төлбөр: 0.00₮
Суурь хураамж: 0₮
Нийт төлбөр: 0.00₮
Таны дансны үлдэгдэл: -200'000.00₮

Баталгаажуулалтын төлбөрийн хэсэг нь банкны системтэй хамтарч ажилдаг учир гүйлгээ хийх картны мэдээллийг тухайн банк хариуцна.

4. ЦАХИМ ЖУРНАЛ

Цахим журнал нь багшийн бүртгэсэн ирцийн мэдээлэл болон багшийн өгсөн даалгаврыг харах, буцаан даалгавраа илгээх, багшийн өгсөн үнэлгээг харах гэх мэт боломжуудтай. Та оюутны цахим

журналыг хэрэглэхдээ системийн нүүр хуудсанд байрлах тухайн улиралд судалж буй хичээл дээр даран гарч ирэх хэсгээс **Журнал** хэсгийг сонгоно.

Судалж буй хичээлүүд

CSSW223 - Объект хандлагат програмчлал (3 кр)

HIST100 - Монголын түүх (3 кр)

ITCM351 - Телехолбооны үндэс (3 кр)

ELEC211 - Электрон элемент ба хэлхээ (4 кр)

ELEC112 - Цахилгаан хэлхээ (3 кр)

COMP223 - Микропроцессор (3 кр)

Хичээлийн мэдээлэл
Хуваарь
Журнал
Санал асуулга эхлээгүй

4.1 Ирц бүртгэл

Цахим журналын ирц бүртгэлийн мэдээллийг харахын тулд **Журнал** хэсгийн гарч ирэх талбараас **Ирц бүртгэл** хэсгийг сонгох ба энд тухайн хичээл дээр оюутан таны лекц, семинар, лабораторийн ирцийн бүртгэл оролт тус бүрээр тайлбарын хамт харагдана.

	Даалгавар						Ирц бүртгэл						
Лекц	2014/2/12	2014/2/19	2014/2/26	2014/2/5	2014/3/12	2014/3/19	2014/3/26	2014/3/5	2014/4/16	2014/4/2	2014/4/23	2014/4/30	<ul style="list-style-type: none"> ✔ - Ирсэн ○ - Чөлөөтэй ! - Өвчтэй ● - Тасалсан
	✔	✔	✔	✔	✔	●	✔	✔	✔	●	●	✔	
Лаборатори	2014/2/13	2014/2/20	2014/2/27	2014/2/6	2014/3/13	2014/3/20	2014/3/27	2014/3/6	2014/4/10	2014/4/17	2014/4/24	2014/4/3	
	✔	✔	✔	✔	✔	✔	✔	✔	✔	✔			

4.2 Даалгавар

Цахим журналын багшийн өгсөн даалгаврын мэдээллийг харахын тулд **Журнал** хэсгийн гарч ирэх талбараас **Даалгавар** хэсгийг сонгох ба энд багшийн өгсөн бүх даалгавруудын мэдээлэл, таны авсан онооны хамт хүснэгт хэлбэрээр харагдана. Мөн тухайн даалгаврын харгалзах **Дэлгэрэнгүй** товчин дээр дарснаар даалгаврын дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

	Даалгавар						Ирц бүртгэл
№	Даалгаврын нэр	Төрөл	Оноо	Эхлэх өдөр	Дуусах хугацаа	Авсан оноо	Дэлгэрэнгүй
1	Lab1	Лаборатори	3	2014/2/20	2014/2/27	3	Дэлгэрэнгүй
2	Lab2	Лаборатори	3	2014/2/24	2014/3/3	3	Дэлгэрэнгүй
3	Lab3	Лаборатори	3	2014/2/27	2014/3/6	3	Дэлгэрэнгүй
4	LAB5	Лаборатори	3	2014/3/20	2014/3/27	3	Дэлгэрэнгүй

Дэлгэрэнгүй товчин дээр дарснаар тухайн даалгаврын дэлгэрэнгүй мэдээлэл гарч ирэхээс гадна тухайн даагавар нь оюутнаас файл хүлээж авах даалгавар бол оюутан та энэ хэсэгт даалгавраа илгээх болно.

Даалгаврын мэдээлэл ×

Даалгаврын нэр: Лекцүүд

Гүйцэтгэх хугацаа: Эхлэх өдөр :2014.6.17- Дуусах өдөр:2014.6.25

Даалгаврын оноо: 0

Лекцийн материал
Татах линк: <http://share.gogo.mn/n0EbsqX8P85731400463677>

Та даалгавраа илгээхийг хүсвэл файлуудаа "Browse..." товчийг дарж сонгоод " илгээх" товчийг дарж илгээнэ үү. Нэгэнт илгээсэн үед дахин илгээх боломжгүй тул файлаа эв сонгож илгээнэ үү.

No file chosen

No file chosen

No file chosen

5. ТӨГСӨХ ХҮСЭЛТ ГАРГАХ

Оюутан та бакалаврын сургалтын журмын дагуу тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд системээр өөрийн төгсөх хүсэлтийг гаргана. Төгсөх хүсэлт гаргахын тулд үндсэн цэсний **Төгсөх хүсэлт** цэсийг сонгоно. Энэ хэсэгт таны төгсөх хүсэлт гаргахад шаардлагатай мэдээллүүд байх бөгөөд доод хэсэгт байрлах **Төгсөх хүсэлт гаргах** товчин дээр дарахад төгсөх хүсэлт илгээгдэх болно.



Суралцагчийн хүсэлт, санал гомдлыг хүлээн авах, барагдуулах

Оюутан та сургалт болон бусад үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж мэдээлэл, дүнгийн тодорхойлолт зэргийг өөрийн суралцаж буй бүрэлдэхүүний сургуулийн зааварлагч нараас авч болох бөгөөд хичээл сонголт, дүнтэй холбоотой асуудлаар хандах бол Сургалтын албаны тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтнээс тодруулна. Таны хүсэлт, санал гомдлын хариу МУИС-ийн төв удирдлага эсвэл Сургалтын нэгдсэн албанаас гарах шаардлагатай бол таны сурч буй сургуулийн сургалтын алба уг асуудлыг дамжуулж хариуг авч оюутанд мэдэгдэнэ.

Сургуулиас олгох бичиг баримт /албан ба албан бус/

МУИС-ийн бүрэлдэхүүн сургуульд суралцагчаар элсүүлэх тухай захирлын тушаал гарсны дараа элссэн суралцагчдад оюутны үнэмлэх олгоно. Үнэмлэхээ гэсэн, үрэгдүүлсэн, хулгайд алдсан тохиолдолд зохих журмын дагуу нөхөн авч болно.

МУИС-ийн суралцагч мөн болох тухай, суралцаж байх үеийн дүнгийн албан ёсны тодорхойлолтыг салбар сургалтын алба эрхлэн олгоно. Дүнгийн албан бус тодорхойлолтыг суралцагч мэдээллийн системээс төлбөргүй авч болно.

Албан ёсны бүх бичиг баримтыг олгоходоо зохих хэмжээний хураамж авна

Сургалтын төлбөр, үйлчилгээний хөлс

Сургалтын төлбөр: 2014-2015 оны хичээлийн жилийн бакалаврын түвшиний сургалтын төлбөр.

№	Бүрэлдэхүүн сургууль	Түвшин	Хичээлийн жилийн суурь хураамж ₮	Нэг багц цагийн төлбөр ₮
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ	I-II	200.000	57.400
		III-IV		44.700
2	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ	I-II	200.000	61.700
		III-IV		44.900
3	БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	I-II	200.000	69.000
		III-IV		46.000
4	ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	I-II	200.000	62.900
		III-IV		45.300
5	ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ	I-II	200.000	65.600
		III-IV		45.600
6	ЗАВХАН, ОРХОН СУРГУУЛЬ	I-IV	200.000	41.000

2014-2015 оны хичээлийн жилийн бакалаврын түвшиний сургалтын төлбөр.

№	Ангилал	Сургалтын агуулга	Хичээлийн жилийн суурь хураамж ₮	Нэг багц цагийн төлбөр ₮
1	Магистр	Судлах бүх төрлийн хичээл, магистрын ажил	300.000	89.600
2	Доктор	Судлах бүх төрлийн хичээл	300.000	112.000
		Докторын ажил		192.400

Дотуур байр: Оюутны дотуур байрны үйлчилгээний төлбөр 400,000 төгрөг

Сургалтын үйлчилгээтэй холбоотой төлбөр хураамж (2014-2015 оны хичээлийн жилийн жил)

Д.д	Төлбөр хураамжийн нэр	Мөнгөн дүн
1.	Элсэлтийн бүртгэлийн хураамж	
	а/ Гадаад оюутан	20\$
	б/ Бакалаврын бүртгэлийн хураамж	9000₮
	в/ Бакалаврын ур чадварын шалгалтын хураамж	4000₮
	г/ Бакалаврын бүртгэлийн хураамж /орой, эчнээ/	10000₮
	д/ Магистрант, докторантын бүртгэлийн	25000₮
2.	Бакалаврын түвшинд суралцах эрхийн бичиг буцаалтын төлбөр	Нэг багц цагийн төлбөр
3.	Хичээл сонголтоос хожимдсон бүртгэлийн хураамж	Нэг багц цагийн төлбөр 1/3
4.	Оюутны үнэмлэхний үнэ /даван/	5000₮
5.	Оюутны болон дүнгийн албан тодорхойлолт олгох үйлчилгээний төлбөр /даван/	500₮
6.	Дүнгийн гомдол барагдуулах үйлчилгээний төлбөр	Нэг багц цагийн төлбөр

		1/3
7.	Дахин судлах хичээлийн багц цагийн төлбөр	Тухайн хичээлийн жилийн нэг багц цагийн төлбөр
8.	Дипломын орчуулга, тодорхойлолт /англи хэлээр/	15000₮
9.	Дипломын хавсралтын орчуулга /англи хэлээр/	20000₮
10.	Диплом, дипломын хавсралтын орчуулга, тодорхойлолт /давтан/	15000₮
11.	Диплом нөхөн олгох	90000₮
12.	Дипломын хавсралт нөхөн олгох	50000₮
13.	Диплом, дипломын хавсралт шинээр олгох	Тухайн жилийн худалдан авалтын үнээр
14.	Энгэрийн тэмдэг	
15.	Төгсөлтийн ёслолын хувцас ашиглалтын төлбөр	5000₮
16.	Шилжилтийн зардал	Тухайн жил хүчин төгөлдөр мөрдөгдөж буй шилжилтийн журмын дагуу
17.	Лавлагаа, тодорхойлолт	5000₮

Тайлбар: Энэ төлбөр хураамж нь нийт суралцагчдад хамаарна.

IV БҮЛЭГ. СУРАЛЦАГЧИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“МУИС-ИЙН ДҮРЭМ”-ЭЭС

9. МУИС-ийн суралцагчид

9.1. МУИС нь Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг яс үндэс, гарал үүсэл, хүйс, шашин шүтлэг, нийгмийн байдлыг харгалзахгүйгээр зөвхөн элсэн суралцах нийтлэг шаардлагыг хангасан нөхцлөөр чөлөөтэй суралцуулна.

9.2. Оюутан (бакалаврын болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн), магистрант, докторант (цаашид „суралцагчид” гэнэ)-ыг элсүүлэх, сургах, төгсгөх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн захирлын баталсан журмаар зохицуулна.

9.3. Суралцагчид нь Монгол Улсын боловсролын хууль болон бусад хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмын дагуу мэдээллээр хангагдах, сургуулийн удирдах зөвлөлд төлөөлөлтэй байх, сургалтын төлөвлөгөөний хүрээнд хичээлийг сонгон судлах, амжилттай суралцсаны тэтгэлэг, дэмжлэг авах, өөрийн ахуй амьдрал, сургалттай холбоотой асуудлаар холбогдох байгууллагад санал хүсэлт тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

9.4. МУИС-ийн сургалт төлбөртэй байх ба суралцагчид зохих журмын дагуу сургалтын төлбөрийн тэтгэлэг авах, хөнгөлөлт эдлэх эрхтэй.

9.5. МУИС-д шилжин сурах оюутны багц цагийг хүлээн зөвшөөрөх асуудлыг холбогдох журмаар зохицуулна.

9.6. Суралцагч Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан эрхийг эдлэхээс гадна:

9.6.1. Суралцаж байхдаа МУИС-ийн материаллаг болон мэдээллийн нөөцийг сургалт, эрдэм шинжилгээний зориулалтаар ашиглах;

9.6.2. Шинжлэх ухааны салбарын орчин үеийн ололтоос суралцах;

9.6.3. Тухайн мэргэжлээр суралцах хөтөлбөрт заасан бүх хичээлийг судлах;

9.6.4. Хичээл болон багшийг чөлөөтэй сонгох;

9.6.5. Шинжлэх ухааны мэдлэг эзэмших зорилгоор профессор, багш нараас тусламж авах;

9.6.6. Эрдэм шинжилгээний ажилд оролцох;

9.6.7. МУИС-ийн үйлчилгээний нэгжүүдээс зохих журам, нөхцлийн дагуу үйлчилгээ авах;

9.6.8. Сургалтын чанарын талаар саналаа илэрхийлэх;

9.6.9. Хууль тогтоомж болон сургуулийн дүрэм, журмын дагуу сургуулийн удирдах байгууллагад сонгогдох, сонгох;

9.6.10. Сурлагын дүнгээс бусад эрхийг тэгш эдлэх;

9.6.11. Хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагаа явуулах эрхтэй.

9.7. Суралцагч дараах үүрэгтэй:

9.7.1. Сургалтын хөтөлбөрт заасан сургалтын бүх хэлбэрийн үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох;

9.7.2. Тогтоосон хугацаанд шалгалтыг өгч сургалтын бусад даалгаварыг гүйцэтгэх;

9.7.3. МУИС-д хүчин төгөлдөр үйлчилж байгаа дүрэм, журмыг баримтлах;

9.7.4. Багш, ажилтан, бусад суралцагчдад хүндэтгэлтэй хандаж, харилцах,

9.7.5. Сайн иргэн, чанартай мэргэжилтэн болохын төлөө өөрийгөө дайчилж, МУИС-ийн эрдмийн нэр хүндийг ямагт хүндэтгэх;

9.7.6. МУИС-ийн нутаг дэвсгэрт эрдмийн ёс зүй, эерэг зан үйлийг чандлан сахих;

9.7.7. МУИС-ийн дүрэм, журмаар тодорхойлсон үүрэг, хариуцлагаа биелүүлэх;

9.8. Сургалт, эрдэм шинжилгээний ажилд өндөр амжилт үзүүлсэн, иргэний идэвх, санаачилга гаргаж, манлайлсан суралцагчийг шагнаж урамшуулна.

9.9. МУИС-ийн дүрэм, журмыг зөрчин буруутай нь тогтоогдсон суралцагчийг сануулах, сургуулиас хөөхөөр сануулах, сургуулиас хөөх зэрэг арга хэмжээг сургууль/Бүрэлдэхүүн сургууль/ саналаар сургуулийн Захирал авна.

9.10. Сахилгын арга хэмжээг зөрчлийг илрүүлснээс хойш 1 сарын дотор авна.

“МУИС-ИЙН БАГШ, АЖИЛТАН, СУРАЛЦАГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ”-ээс

2.4 Суралцагчийн дагаж мөрдөх хэм хэмжээ

2.4.1. Суралцах үйл ажиллагаанд дагаж мөрдөх хэм хэмжээ

МУИС-ийн суралцагч бүр эрдэм мэдлэг эзэмших зорилгоо эрхэм болгож, ямагт өөрийгөө хөгжүүлж, сурлагадаа ахиц дэвшил гаргаж байх нь суралцагчийн эрх ашигт бүрэн нийцэх төдийгүй улс орны хөгжил цэцэглэлтийн үндэс мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

154. Суралцагч нь багш шавийн барилдлагыг хүндэтгэх;
155. МУИС-ийн суралцагчдын дүрэм, журам, заавар, зөвлөмжтэй танилцаж, дагаж мөрдөх;
156. Хичээлийн хөтөлбөр, хуваарь, цаг баримтлах;
157. Хичээлийн цагийг зүй зохистой, үр бүтээлтэй ашиглах;
158. Даалгавар, ангийн ажил, бие даалтыг цаг хугацаанд нь гүйцэтгэх, хүлээлгэн өгөх;
159. Сургуулийн өмч хөрөнгө, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, гарын авлага, анги танхимын эд хогшил, ширээ сандлыг ариг гамтай эдэлж ашиглах;

Хориглосон хэм хэмжээ

160. Хичээл таслах, хичээлээс хоцрох, хичээл дундуур гарч явах;
161. Хичээлийн цагаар бусдын сурах үйл ажиллагаанд саад учруулах, бусдын тавьсан шаардлагыг үл ойшоож хичээлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах;
162. Шалгалтын ажлыг гүйцэтгэх явцад бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл авах, шалгалтанд зөвшөөрөгдөөгүй материал авч орох, ашиглах, гар утас, цахим хэрэгсэл хэрэглэх;
163. Бусдын өмнөөс шалгалт өгөх, бусдыг өөрийнхөө өмнөөс шалгалтанд оруулах;
164. Бие даан гүйцэтгэхээр заасан лабораторийн ажил, дадлага, судалгааны ажил, хичээлийн бие даалт гүйцэтгэхдээ бусдаар хийлгэх, бусдын хийсэн зүйлийг хуулбарлах;
165. Лабораторийн ажил, судалгааны үр дүн бусад даалгаврыг хуурамчаар зохиомлоор үйлдэх;
166. Хичээлийн даалгавар, бие даалтын ажил, гүйцэтгэхдээ бусдын хийсэн ажил, дэвшүүлсэн санааг өөрийн болгож хууран мэхлэх. Үүнд, дараах тохиолдолд хууран мэхэлсэн гэж үзнэ;
 - 166.1. Бусдын бүтээлийг хуулсан;
 - 166.2. Өөр үгээр илэрхийлсэн боловч утга санаа нь хэвээр хадгалагдсан;
 - 166.3. Бусдын санааг зөвшөөрөлгүй, зүй бусаар ашигласан;
167. Нэг хичээлийн даалгаврын гүйцэтгэлд шалгуулж үнэлгээ авсан ажлыг өөр хичээлийн даалгаварт шалгуулж, давхар үнэлүүлэх;
168. Багшийн өгсөн дүн, оноог засч үнэлгээг өөрчлөх;
169. Дүнгийн хуудас, сурлагын дэвтэр, оюутны үнэмлэх, биеийн байцаалт, хөнгөлөлтийн хуудас, тодорхойлолт зэрэг албан бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, засвар оруулах, өөрчлөх, зүй бусаар бусдад дамжуулах, ашиглуулах;
170. Суралцах явцад бусадтай шударга бусаар өрсөлдөх. Үүнд, дараах тохиолдолд шударга бусаар өрсөлдсөн гэж үзнэ:
 171. Өөртөө болон хэн нэгэнд шударга бусаар давуу байдал бий болгох;
 172. Сургалтын материалыг бусдаас хулгайлах, нуун дарагдуулах, өөрчлөх;
 173. Дүгнэх аргачлалыг будлиулах;
 174. Хичээлийн цагаар хичээлд холбогдолгүй зүйл хийх, утсаар ярих, мессеж бичих, тоглох, дуу хөгжим сонсох зэргээр цахим хэрэгслийг хичээлийн бус зориулалтаар ашиглах;
 175. Сургалтын хэрэглэгдэхүүн, номын сангийн сурах бичиг, гарын авлагыг зүй зохисгүй ашиглах, гэмтээх, устгах, дахин ашиглах боломжгүй болгох;

2.4.2. Суралцах үйл ажиллагаанаас бусад хүрээнд дагаж мөрдөх хэм хэмжээ

176. Багш, ажилтан, ажилчид, бусад суралцагчидтай харилцааны өндөр соёлтой, хүндэтгэлтэй харилцах;
177. Сургуулийн орчинд ашиглагдаж буй эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг ариг гамтай зориулалтын дагуу зөв ашиглаж, зөв боловсон үйлчлүүлэх;

Хориглосон хэм хэмжээ

178. Анги, курс, хот хөдөө, нас, физиологийн зэрэг ялгаа үүсгэн бусдыг айлган сүрдүүлэх эрхшээлдээ оруулах, зодож гэмтээх, элдэв татаас татах, дарамтлах, нэр төр, үнэ хүндийг нь гутаах;

179. Хуурамч дуудлага өгөх, бусдыг хилсээр буруутгах, мэдээллийг буруутгах, мэдээллийг гуйвуулах, нуун дарагдуулах, худал мэдээлэх, хутган үймүүлэх, бусдыг гүтгэх, худал мэдүүлэх зэрэг ноцтой үйлдэл гаргах;

180. Сургуулийн эрх бүхий албан тушаалтан, багш, ажилтан, ажилчид, суралцагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, биеийн байцаалтаа гаргаж өгөхгүй байх, сахилгын арга хэмжээг үл биелүүлэх;

181. Сургуулийн анги, танхим, албан тасалгаа, дотуур байранд зөвшөөрөлгүй нэвтрэх, дотор нь байрлах;

182. Сургуулийн орчинд хэт чанга дуу авиа гаргах, орилох, исгэрэх, чанга инээлдэх, хөгжим дуугаргах;

183. Сургуулийн орчинд элдэв хог, шүлс, нус цэр, бохь, тамхины иш хаях, цонх тагнаас элдэв юм шидэх, тамхи татах;

184. Цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалтын ажилчдыг үл ойшоох, хөдөлмөрийг нь үл хүндлэх;

185. Хуулиар зөвшөөрсөн эсэхээс үл хамааран сургуулийн зохих албан тушаалтан зөвшөөрсөн, сургуулийн дүрэм, журамд зааснаас бусад тохиолдолд халуун, хүйтэн зэвсэг, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх шатамхай бодис зэрэг аюултай зэвсэг, хэрэгсэл ашиглах, хадгалах, эзэмшилдээ байлгах;

186. Хуулиар хориглосон арга, хэлбэрээр мансууруулах бодис хэрэглэх, үйлдвэрлэх, түгээх, борлуулах, эзэмшилдээ байлгах;

187. Сургуулийн газар хөзөр, компьютерийн тоглоом зэргээр тоглох, мөрийтэй тоглох;

(Дэлгэрэнгүйг <https://sisi.num.edu.mn/files/Durem%20juram/>)

СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

/оюутны тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээ/

Суралцагч тухайн хичээлээр улирлын түршид эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргахдаа хичээлийн явцын идэвх оролцоо, бие даасан ажиллагааны завсрын хяналтын үнэлгээ, улирлын шалгалтын үнэлгээ тус бүрийг зохих хэмжээгээр тооцон 100 оноогоор үнэлнэ.

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргахдаа дараах аргачлалыг баримтлана.

$$O = O_1 + O_2 + O_3$$

Үүнд:

O₁ - *Идэвх, оролцооны үнэлгээ.* Хичээлд оролцсон бүтээлч ирц, семинар, дадлагын хичээлд бэлтгэсэн байдал зэрэгт багшийн өгсөн үнэлгээ бөгөөд 20-40 оноо байна.

O₂ - *Суралцагчийн явцын үнэлгээ.* Улирлын явцад хийсэн илтгэл, реферат, тайлан, хяналтын ажил, коллеквиум, сэдвийн үнэлгээний дундаж бөгөөд 20-40 оноо байна.

O₃ - *Улирлын шалгалтын үнэлгээ* бөгөөд 20-60 оноо байна.

Бакалаврын зэрэг олгох сургалтанд тухайн хичээлд 60 ба түүнээс дээш оноо авсан оюутныг уг хичээлийн агуулгыг судалж, багц цагийг биелүүлсэн гэж үзнэ. Харин 60-аас бага оноо авсан оюутныг “хангалтгүй” суралцсан буюу тухайн хичээлийн багц цагийг биелүүлээгүй гэж үзнэ.

Магистр, докторын зэрэг олгох сургалтанд тухайн хичээлд 60 ба түүнээс дээш оноо авсан оюутныг уг хичээлийн агуулгыг судалж, багц цагийг биелүүлсэн гэж үзнэ. Харин 60-аас бага оноо авсан оюутныг “хангалтгүй” суралцсан буюу тухайн хичээлийн багц цагийг биелүүлээгүй гэж үзнэ.

Кредит тооцохгүй хичээлийн шалгалтыг авахдаа шалгалтын адил 100 оноогоор үнэлнэ. Оюутны авсан оноо нь 60 ба түүнээс дээш бол “тооцов”, 60-аас доош бол “үл тооцов” гэж дүгнэх бөгөөд үнэлгээг харгалзан “S”, “U” гэж бичнэ.

Хувьчилсан оноо, үсгээр илтгэсэн дүн ба тоогоор илтгэсэн дүнгийн хоорондын холбоо дараах хэлбэртэй байна. Үүнд:

Хувьчилсан оноо	Үсгээр илтгэсэн дүн	Тоогоор илтгэсэн дүн
95-100	A	4.0
90-94	A-	3.6
85-89	B	3.1
80-84	B-	2.7
75-79	C	2.3
70-74	C-	1.9
65-69	D	1.4
60-64	D-	1.0
0-59	F	0

Суралцагчийг үнэлэхдээ тоо болон үсгээр илтгэсэн дүнг хэрэглэхээс гадна I, E, NC, CR, R, W, WF, NA, NR, S, U гэсэн нэмэлт тэмдэглэгээг хэрэглэнэ. Эдгээр тэмдэглэгээ нь оюутны голч дүн буурах шалтгааныг тогтоох, оюутан голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох, бусад сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох зэрэгт хэрэглэгдэнэ. Нэмэлт тэмдэглэгээг дор үзүүлэв.

I	(Incomplete) Хүндэтгэн үзэх шалтгаанаар явцын үнэлгээ (реферат, даалгавар, дадлагын ажил дутуу, явцын шалгалтанд орж чадаагүй гэх мэт) дутуу боловч шалгалтын хугацаанд нөхөн гүйцэтгэж, шалгуулах нөхцөлтэйгээр хэрэглэнэ.
E	(Examine incomplete by student) Хүндэтгэн үзэх шалтгаанаар улирлын шалгалтанд ороогүй бол багш (эсвэл салбар сургалтын албаны эрхлэгч) энэ тэмдэглэгээг бичнэ.
NC	(No Credit) Багц цаг тооцохгүй бөгөөд уг хичээлийг оюутан судалсан гэсэн тэмдэглэгээ. Кредит тооцуулахгүйгээр хичээл судлах зөвшөөрөл авч амжилттай судалсан тохиолдолд тавигдах тэмдэглэгээ юм.
CR	(Credit Ranted) Өөр сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох үед энэ тэмдэглэгээг хийх ба дипломын хавсралтан дээр энэ хэвээрээ бичигдэнэ.
R	(Repeat) Тухайн хичээлийг амжилттай судалсан ч тодорхой шаардлагаар дахин судлах хүсэлт гаргасан бол оюутны өмнөх үнэлгээний үсгээр илтгэсэн дүнг R болгож, дахин судлах боломжоор хангана.
W	(Withdrew) Хэрэв оюутан хичээлийг цаашид судлах боломжгүй эсвэл хангалтгүй судалсан бол улирлын шалгалтаас өмнө өөрийн саналаар уг тэмдэглэгээг багшид хүсэлт гаргаж хийлгэнэ. Дараа нь тус хичээлийг шинээр үзэх хичээлийн адил бүртгүүлж судална.
NA	(grade Not yet Available) Одоогоор дүгнэгдээгүй буюу судалж байгаа хичээлийн тэмдэглэгээ.
NR	(No grade Reported) Багш эцсийн үнэлгээгээ үнэлгээ тавих хугацааны дотор тавьж, системд оруулаагүй тохиолдолд мэдээллийн системээс автоматаар тавьсан тэмдэглэгээ.
S	(Satisfactory) "Тооцов" тэмдэглэгээ.
U	(Unsatisfactory) "Үл тооцов" тэмдэглэгээ.

Хүндэтгэх шалтгаангүйгээр улирлын шалгалтанд ирээгүй оюутанд “F” буюу “хангалтгүй” үнэлгээ тавина. Харин хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол нотлох бичиг баримтыг үндэслэн “E” тэмдэглэгээг хийнэ. I, E тэмдэглэгээтэй оюутан дараагийн улирлын эхний I сард багтаан шалгуулахгүй бол салбар сургалтын албанаас F дүн тавина.

Нэмэлт тэмдэглэгээ тавигдсан хичээлийн багц цагийг улирлын болон нийт голч оноо, голч дүнг бодоход хэрэглэхгүй.

Явцын үнэлгээ нь тухайн хичээлийн туршид эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг олж авахын тулд оюутны хэрхэн хөдөлмөрлөснийг үнэлэх үзүүлэлт юм.

Багш явцын үнэлгээг хэрхэн үнэлж, дүгнэхээ хичээлийн эхэнд оюутнуудад мэдэгдсэн байна.

Багш зааж байгаа хичээлээрээ оюутныг тасралтгүй, жигд үнэлэн дүгнэхдээ, явцын шалгалтыг 1-2 удаа авсан байна. Багш явцын шалгалтыг сургалтын албанд хандан тестээр авч болно.

Явцын үнэлгээний дэг журам (бусдаас хуулах, өөр оюутныг өөрийн нэрээр шалгалтанд оруулах, зөвшөөрөгдөөгүй ном, дэвтэр ашиглах зэрэг) зөрчсөн тохиолдолд протокол хөтлөн, тухайн оюутанд F дүн тавьж, ёс суртахууны зөрчил гаргасанд тооцож, салбар сургалтын албанд мэдэгдэнэ.

Улирлын шалгалт нь оюутны тухайн хичээлээр эзэмшсэн онолын мэдлэгээ танин мэдэхүйн болон практик үйл ажиллагаанд хэрэглэх чадварыг дүгнэхэд чиглэнэ.

Улирлын шалгалтыг тухайн улирлын хичээл дууссаны дараа 21 хоногт багтаан авах бөгөөд шалгалтын хуваарийг багшийн саналыг харгалзан салбар сургалтын албаны эрхлэгч баталж, шалгалт эхлэхээс 2 долоо хоногийн өмнө багш, оюутанд мэдээлж, мэдээллийн системд байршуулсан байна.

Эчнээ хэлбэрээр суралцаж буй оюутны хувьд шалгалтыг улирлын төгсгөлд, эсвэл дараагийн улирлын эхэнд зохион байгуулна. Суралцагч бие дааж гүйцэтгэх даалгаврын биелэлтийг шалгалт эхлэхээс 21 хоногийн өмнө шалгагч багшид ирүүлсэн байна.

Улирлын шалгалтыг амралтын өдрүүдэд авахыг зөвшөөрнө.

Тусгай төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа буюу хүндэтгэн үзэх гарцаагүй шалтгаантайн улмаас тухайн хичээлийн улирлын шалгалтыг хуваарьт хугацаанд өгөх боломжгүй тохиолдолд оюутан тэр тухайгаа салбар сургалтын албаны эрхлэгчид урьдчилан мэдэгдэж, шалгалтыг салбар сургалтын албаны эрхлэгчийн баталсан чөлөөт хуваариар урьдчилан болон нөхөн өгч болно. Нөхөн өгөх тохиолдолд тухайн оюутныг дараагийн улирлын эхний 14 хоногт багтаан шалгалтаа өгөх болзолтойгоор хичээлд суухыг зөвшөөрнө. Шалгалтаа өгч, бусад шаардлагыг хангасан нөхцөлд үргэлжлүүлэн суралцуулна. Бусад тохиолдолд, жишээ нь оюутан гадаад оронд ажиллах хөтөлбөрт хамрагдах, жуулчлах бол шалгалтын хугацааг өөрчлөхийг зөвшөөрөхгүй.

Гадаад хэл, компьютерийн зохих мэдлэгтэй оюутан хүсэлт гаргавал, улирлын эхэнд түвшин тогтоох шалгалт авч, бие даан суралцуулах буюу тухайн хичээлээс (улмаар улирлын шалгалтаас) чөлөөлж болно.

Улирлын явцад хичээлд байнга идэвхтэй оролцсон, тухайн хичээлийн явцын шалгалтын бүх хэлбэрүүдэд амжилттай үнэлэгдсэн, үлгэр жишээч оюутанд уг хичээлийн улирлын шалгалтын үнэлгээг шууд тавихыг үгүйсгэхгүй бөгөөд уг асуудлыг багш оюутны хамт олонд мэдэгдэн, ил тод шийднэ. Шууд дүгнэгдэх оюутны тоо нийт шалгагдах оюутны 10%-аас хэтрэхгүй байвал зохино.

Дахин судлах хичээлийн үнэлгээ. Заавал судлах хичээлийг судалж, амжилтгүй дүн авсан, мөн “R”, “W”, “U” үнэлгээний тэмдэглэгээтэй оюутан тухайн хичээлийн багц цагийг биелүүлэхийн тулд дахин судлах шаардлагатай. Оюутан тухайн хичээлийг судалж, амжилттай үнэлгээ авсан ч тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, үнэлгээгээ ахиулах зорилгоор дахин судалж болно. Дахин судлах хичээлийн тоо 3 хүртэл байх ба нэг хичээлийг нэг л удаа дахин судалж болно.

Дүнгийн талаарх гомдлыг барагдуулах. Суралцагчийн шалгалтын дүнг хүлээн авсны дараа алдаатай гэж үзэж байвал уг дүнг хянан магадлуулахаар хүсэлт гаргаж болно. Хүсэлтийг дараа улирлын эхний 21 хоногт багтан салбар сургалтын албаны эрхлэгчид бичгээр гаргах ба энэ хугацаанаас хэтэрч гаргасан гомдлыг хүлээн авахгүй.

(Дэлгэрэнгүйг: МУИС-ийн сургалтын журмаас үзнэ үү)

ҮРГЭЛЖЛҮҮЛЭН СУРАЛЦАХ, ЧӨЛӨӨ АВАХ

Суралцагч тухайн улиралд судлах хичээлдээ бүртгүүлж, улирлын сургалтын төлбөр болон суурь хураамж төлснөөр үргэлжлүүлэн суралцах эрх баталгаажина.

Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаанаар 1 сараас дээш хугацаагаар хичээлд сууж чадахгүйд хүрвэл, салбар сургалтын албанд улирлын чөлөө авах тухай хүсэлт бичгээр гаргана. Чөлөө олгох тухай салбар сургалтын албаны эрхлэгчийн шийдвэрийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна. Суралцагчийн суралцах хугацаанд олгох чөлөөний нийт хугацаа 2 жилээс хэтрэхгүй байна.

Улирлын чөлөөг зөвхөн тухайн улирлын эхнээс тооцож олгох бөгөөд чөлөөний хугацаа дуусахад энэ журмын 4.4-д заасны дагуу хичээлд бүртгүүлж, үргэлжлүүлэн суралцана. Чөлөөний хугацаа дуусч, үргэлжлүүлж суралцах эрх нь нээгдсэн оюутан салбар сургалтын алба, харьяалагдах тэнхимээс суралцах хувийн төлөвлөгөө зохиох, хичээлд бүртгүүлэх, бусад асуудлаар зөвлөгөө авах шаардлагатай.

Улирлын чөлөө авах тохиолдолд тухайн улирлын суурь хураамжийг буцааж олгохгүй бөгөөд хичээлийн багц цагийн төлбөрийг энэ журмын 4.18.2-д заасны дагуу зохицуулна.

Чөлөөний хугацаа дууссан суралцагч улирлын эхний долоо хоногт үргэлжлүүлэн суралцах өргөдлөө бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд өгч тухайн хичээлийн жилийн эхний улирлын сургалтын болон бусад шаардлагатай төлбөрийг төлсний үндсэн дээр бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар үргэлжлүүлэн суралцах эрх нээгдэнэ.

Суралцагчийн чөлөөтэй байсан хугацааг суралцсан хугацаанд тооцохгүй.

Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаанаар 1 сараас доош хугацаагаар чөлөө авах бол хүсэлтээ бичгээр гаргаж багшийн зөвшөөрлөөр сургалтын алба шийдвэрлэнэ.

Суралцагчийн чөлөөний хуудасны загварыг сургалтын нэгдсэн албанаас батална.

(Дэлгэрэнгүйг: МУИС-ийн сургалтын журмаас үзнэ үү)

СУРГУУЛИАС ЧӨЛӨӨЛӨХ, ХАСАХ

Суралцагч сургуулиас чөлөөлөгдөх тухай хүсэлтийг Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албанд гаргасан тохиолдолд сургуулиас бүрмөсөн чөлөөлөх МУИС-ийн захирлын тушаал гарна.

Улирлын хичээл эхэлснээс хойш, сургалтын төлөвлөгөөн дэх тухайн хичээлийн цагийн 30 хувь өнгөрөөгүй байхад суралцагч сургуулиас чөлөөлөгдөх бол багц цагийн төлбөрийн 70 хувийг буцаан олгоно. Хичээлийн цагийн 30-аас дээш хувь өнгөрсөн бол багц цагийн төлбөр, буцаан олгохгүй.

Суралцагчийг дараах шалтгаанаар Бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн шийдвэрээр МУИС-ийн захирлын тушаалаар сургуулиас хасна. Үүнд:

- Суралцах хугацаа хэтэрсэн,
- Суралцах үлдсэн хугацаанд нийт багц цагийг амжилттай цуглуулж чадахгүй нөхцөлд орсон,
- Эзэмшсэн мэдлэг, чадвараа үнэлүүлэхдээ хуурч мэхлэх, дүнгийн тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх зэрэг зөрчил давтагдвал,
- Гэмт хэрэг, ёс суртахууны ноцтой зөрчил гаргасан нь хууль, хяналтын байгууллагаар тогтоогдвол.

Суралцагч сургуулиас хасагдах тохиолдолд ямар ч төлбөрийг буцааж олгохгүй.

(Дэлгэрэнгүйг: МУИС-ийн сургалтын журмаас үзнэ үү)

ХӨТӨЛБӨР ХООРОНД ШИЛЖИН СУРАЛЦАХ

Гурав. МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцах

3.1. Дараах нөхцлийг хангасан МУИС-ийн бакалаврын түвшний оюутан өөр хөтөлбөрт шилжин суралцах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:

3.1.1. МУИС-д элсэх болзол хангаж элсэн, 2-оос доошгүй улирал 2.8-аас багагүй голч дүнтэй суралцсан, улиралд дунджаар 12-оос багагүй багц цаг цуглуулсан байх,

3.1.2. Мэргэжлийн хөтөлбөр хоорондын элсэлтийн ерөнхий шалгалтын зөрүүгүй байна. Хэрэв үндсэн шалгалт 70% дагалдах шалгалт 30% гэсэн харьцаатайгаар элссэн тохиолдолд үндсэн шалгалтын зөрүүгүй байх,

3.1.3. Суралцаж байгаа хөтөлбөртөө хөнгөлөлттэй нөхцлөөр, эсвэл аль нэг байгууллагын гэрээний дагуу элсээгүй байх,

3.1.4. 3-аас доош түвшний оюутан байх,

3.1.5. Сургалтын төлбөрийн өргүй байх.

3.2. Дараах нөхцлийг хангасан МУИС-ийн магистр, докторын түвшний оюутан өөр хөтөлбөрт шилжин суралцах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:

3.2.1. МУИС-ийн магистр, докторын түвшний хөтөлбөрт элсэх болзол хангаж элсэн, нэгээс доошгүй улирал 2.8-аас багагүй голч дүнтэй суралцаж 6-аас багагүй багц цаг цуглуулсан байх,

- 3.2.2. Шилжин суралцах сургуулийн профессортой судалгааны чиглэлээ зөвлөлдөж удирдах зөвшөөрөл бичгээр авсан байх,
3.2.3. Сургалтын төлбөрийн өргүй байх.

(Дэлгэрэнгүйг: Суралцагч шилжүүлэн суралцуулах журмаас үзнэ үү)

ТӨГСӨГЧДӨД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Төгсөгч нь МУИС-д зохих журмын дагуу захирлын тушаалаар элссэн, сургалтын төлөвлөгөөний дагуу тухайн үндсэн мэргэшлийн хөтөлбөрийн заавал болон сонгон суралцах хичээлүүдийг амжилттай судалж, тэнхим/профессорын багаас холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн байна.

Бакалаврын төгсөгч хавсрага мэргэшлээр, эсвэл суралцаж байгаа чиглэлээсээ өөр давхар мэргэжлээр суралцсан тохиолдолд тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний дагуу заавал болон сонгон суралцах хичээлүүдийг амжилттай судалж, мэргэжлийн тэнхим/профессорын багаас холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн байна.

Сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийг бүрэн судалж, 120-оос доошгүй багц цаг цуглуулсан оюутныг дээд боловсролын бакалаврын зэргээр төгсгөнө.

Магистрын төгсөгч хичээлийн жилд 2 удаа 6, 2-р сард магистрын зэрэг олгох төгсөлтийг хийнэ. Суралцагч танхимд судлах 22 багц цагийг цуглуулж, эрдэм шинжилгээний 4 багц цагийн ажлуудыг хийж дүүргэснээр магистрын ажил хамгаалах эрхтэй болно. Хамгаалалт урьдчилсан хэлэлцүүлэг ба хамгаалалт гэсэн 2 үе шаттайгаар явагдана. Магистрант оюутан сургалтын бүх багц цагаа хугацаандаа цуглуулсан боловч магистрийн ажил бичих багц цагаа биелүүлж амжаагүй бол 2 жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Дахин хамгаалалтанд орох хүсэлтээ бүрэлдэхүүн сургуулийн СНА-д гаргаж тухайн хичээлийн улирлын суурь хураамжийг төлнө.

Магистрант оюутан сургалтын бүх багц цагаа хугацаандаа цуглуулсан боловч магистрийн ажил бичиж амжихгүй бол МУИС-ийн магистрын сургалт дүүргэсэн тухай захирлын тушаал гаргаж, гэрчилгээ олгоно. Магистрант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 3 жилийн дотор эрдэм шинжилгээний багц цагаа гүйцээн магистрын ажил бичиж хамгаалах эрхтэй байна.

Магистрын ажил нь тухайн шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлсэн судалгаа, туршилт, боловсруулалт, дүн шинжилгээ, онол арга зүйн зохих түвшинд гүйцэтгэж, тухайн асуудлын шинжлэх ухааны үндэслэл, онол практикийн дүгнэлт зэрэг үр дүнд хүрсэн эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл байх шаардлагыг хангасан байна. Магистрын ажлыг МУИС-ийн захирлын тушаалаар баталсан загвар, шаардлагын дагуу бичиж хэвлүүлнэ. <http://graduate.num.edu.mn/>

Магистрын ажлын хамгаалалтын өмнөх хэлэлцүүлгийг тэнхим эрдэм шинжилгээний өргөтгөсөн семинарт хийнэ. Өргөтгөсөн семинараас дүгнэлт гаргаж, хуралдааны протоколын хамт бүрэлдэхүүн сургуулийн СНА-д хүргүүлнэ. Магистрын ажлыг тухайн бүрэлдэхүүн сургуулийн магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална.

Зэрэг хамгаалсан магистрант оюутан магистрын дипломын хуулбар, зохих шаардлагыг ханган бүрэн эцэслэсэн, удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан магистрын ажил, докторын диссертацийг СНА-д хүлээлгэн өгөх бөгөөд энэ нь МУИС-ийн сургуулийн архив болон номын санд хадгалагдана.

Докторын төгсөгч хичээлийн жилд 2 удаа 6, 2-р сард докторын зэрэг олгох төгсөлтийг хийнэ. Суралцагч танхимд судлах 30 багц цагийг цуглуулж, эрдэм шинжилгээний 18 багц цагийн ажлуудыг хийж дүүргэснээр докторын диссертацийн ажил хамгаалах эрхтэй болно. Хамгаалалт урьдчилсан ба жинхэн хамгаалалт гэсэн 2 үе шаттайгаар явагдана. Докторант оюутан сургалтын хугацаандаа танхимд үзэх бүх багц цагаа цуглуулсан боловч эрдэм шинжилгээний ажлын багц цагаа цуглуулаагүй эсвэл диссертацийн ажил бичиж амжаагүй бол МУИС-ийн доктрантурын сургалт дүүргэсэн тухай МУИС-ийн захирлын тушаал гаргаж, гэрчилгээ олгоно. Докторант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 5 жилийн дотор эрдэм шинжилгээний багц цагаа гүйцээн, диссертацийн ажил бичиж хамгаалах эрхтэй байна. Дахин хамгаалалтанд орох

хүсэлтээ бүрэлдэхүүн сургуулийн СНА-д гаргана. Ингэхдээ тухайн хичээлийн улирлын суурь хураамжийг төлөх шаардлагатай байдаг.

Докторын диссертац нь тухайн мэргэжлийн салбарын мэдлэгт холбогдол бүхий зорилтыг шийдсэн, эсвэл улс орны нийгэм, эдийн засагт холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй (арга, аргачлалын дагуу нотлон)-гээр шийдсэн, урьд өмнө хийгдсэн мэдэгдэж буй бусад шийдлүүдтэй харьцуулж, бүтээлчээр шинэлэг талыг нээн харуулсан, тухайн сэдвээр шинэ мэдлэг мэдээлэл, үндэслэл, онол практикийн дүгнэлт гаргасан эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл байх шаардлагыг хангасан байна.

Докторын зэрэг горилсон диссертацийн урьдчилсан хэлэлцүүлгийг бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн эрдэмтдээр өргөтгөсөн их семинарт хийнэ. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ. Семинараас диссертацид мэргэжлийн дүгнэлт хийж, хуралдааны протокол гаргах ба энэ нь докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд МУИС-иас гаргаж өгөх дүгнэлтийн нэг үндэслэл болно.

Докторант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, сургалтын төлбөрөө төлсөн, диссертацийн ажлаа тэнхим/бүрэлдэхүүн сургуулийн өргөтгөсөн семинарт урьдчилан хэлэлцүүлсэн тухай МУИС-ийн СНА-ны дүгнэлт гарган докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжлана.

Докторын диссертацыг МУИС-ийн захирлын баталсан “докторын диссертацийн эх бэлтгэх, хэвлүүлэх, диссертац хүлээлгэн өгөхөд баримтлах журмын” дагуу бичиж, хэвлүүлнэ. <http://graduate.num.edu.mn/>

Хамгаалах хурлаар докторын диссертацаа хамгаалж чадаагүй бол 3 жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Дахин хамгаалалтанд орох хүсэлтээ докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн даргад гаргаж шийдвэрлүүлнэ.

Диссертацыг монгол хэлээр бичнэ. Диссертацын тухай товч танилцуулгыг англи хэлээр 3 хуудаст багтаан бичиж, диссертацын эцэст хавсаргана. Горилогчийн хүсэлт, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн дийлэнх олонхийн зөвшөөрснөөр диссертацын ажлыг англи хэлээр бичүүлж, хамгаалалтыг англи хэлээр явуулж болно. Энэ тохиолдолд диссертацын тухай товч танилцуулгыг монгол хэлээр бичнэ.

Зэрэг хамгаалсан докторант оюутан докторын зэрэг олгосон дипломын хуулбар, хамгаалуулах зөвлөлийн хуралдааны протокол, тогтоол, удирдагчийн тодорхойлолт, зохих шаардлагыг ханган бүрэн эцэслэсэн, удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан магистрын ажил, докторын диссертац материалыг хамт сургуулийн архив болон номын санд хадгална. Диссертацын хувийг Үндэсний номын сан, Мэдээллийн технологийн үндэсний парк, түшиглэсэн болон суралцагчийн суралцсан сургуулийн номын санд хүлээлгэн өгнө.

Докторант оюутан албан ёсны зөвшөөрөлгүйгээр нэг хичээлийн жилд сургалт, судалгааны ажилд ороогүй, сургалтын төлбөрөө төлөөгүй бол түүнийг сургуулиас хасна.

(Дэлгэрэнгүйг: МУИС-ийн сургалтын журмаас үзнэ үү)

“СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ТЭТГЭЛЭГ, СУРГАЛТЫН ТӨЛБӨР ОЛГОХ ЖУРАМ”-аас

2. Үндэсний тэтгэлэг

2.1. Суралцагчид тэтгэлэг олгох дээд боловсролын сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар аттестатчилагдсан байх;

2.1.2. Нийт төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг төгссөнөөс хойш хагас жил, жилээр гаргаж хэвшсэн байх;

2.1.3. Төгсөгчдийн судалгаагаар тэтгэлэг олгогдохоос 2 жилийн өмнөх төгсөгчдийн 30 хувь нь мэргэжлээрээ ажлын байраар хангагдсан байх;

2.1.4. Оюутны үйлчилгээ, төгсөгчидтэй ажиллах бүтэцтэй байх;

2.1.5. Удирдлагын мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлсэн байх;

2.1.6. Сургуулийн нэрэмжит тэтгэлэг олгодог байх.

2.2. Дараах шаардлагыг хангасан диплом, бакалаврын хөтөлбөрийн суралцагчид үндэсний тэтгэлэг олгоно:

- 2.2.1. Элсэлтийн журмын шаардлагыг ханган элссэн өдрийн ангийн суралцагч байх;
 - 2.2.2. Хичээлийн жилийн нэг улиралд 12-оос доошгүй багц цагийн хичээл судалж, дүгнүүлсэн байх.
- 2.3. Дараах шаардлагыг хангасан магистр, докторын хөтөлбөрт суралцагчид үндэсний тэтгэлэг олгоно:
- 2.3.1. Магистрын хөтөлбөрт шинээр элсэгчийн бакалаврын дипломын голч дүн нь 2.8-аас доошгүй байх;
 - 2.3.2. Докторын хөтөлбөрт шинээр элсэгчийн магистрын дипломын голч дүн нь 3.0-аас доошгүй байх;
 - 2.3.3. Хичээлийн жилийн нэг улиралд 10-аас доошгүй багц цагийн хичээл судалж, дүгнүүлсэн байх.
- 2.4. Үндэсний тэтгэлгийг нэг хичээлийн жилд 10 хүртэлх сарын турш олгоно. Тэтгэлэг олгох нийт хугацаа нь тухайн мэргэжлийн сургалтын хөтөлбөрт заасан жилээс хэтрэхгүй байна.

3. Урамшууллын тэтгэлэг

- 3.1. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад сурлагын өндөр амжилт гарган суралцаж байгаа болон тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр өдрийн ангид амжилттай суралцаж байгаа суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно.
- 3.2. Тусгай шаардлага хангасан суралцагчид урамшууллын тэтгэлгийг үндэсний тэтгэлгийн хэмжээнээс хувиар тооцон нэмж олгоно.
- 3.3. Тухайн улирлын урамшууллын тэтгэлгийг өмнөх улирлын голч дүнг харгалзан олгоно.
- 3.4. Дараах тусгай шаардлагыг хангасан диплом, бакалаврын хөтөлбөрт суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно:
- 3.4.1. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж нь 720-иос дээш оноотой шинээр элсэгчид, 3.4 болон түүнээс дээш голч дүнтэй суралцагчид 50 хувийн;
 - 3.4.2. 3.8 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа суралцагчид 75 хувийн;
 - 3.4.3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохион байгуулсан улсын олимпиадад эхний гурван байрт шалгарсан, олон улсын олимпиадад шагналт байр эзэлсэн шинээр элсэгчид эхний хичээлийн жилд 100 хувийн.
- 3.5. Дараах тусгай шаардлагыг хангасан магистр, докторын хөтөлбөрт суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно:
- 3.5.1. 3.6-аас дээш голч дүнтэй суралцсан өдрийн ангийн магистрант, докторантад 75 хувийн;
 - 3.5.2. Хөндлөнгийн хянан магадлагаа бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд нэгээс доошгүй өгүүлэл хэвлүүлсэн магистрант, докторантад 100 хувийн;
- 3.6. Урамшууллын тэтгэлгийг давхардуулан олгохгүй.

4. Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал

- 4.1. Дараах суралцагчид сургалтын төлбөр олгоно:
- 4.1.1. Бүтэн өнчин суралцагч;
 - 4.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагч;
 - 4.1.3. Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч;
 - 4.1.4. Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн;
 - 4.1.5 багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь.
- 4.2. Дараах суралцагчид амьжиргааны зардал олгоно:

4.2.1. Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүй суралцаж байгаа Монгол Улсын иргэн;

4.2.2. Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн;

4.2.3 багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа хөдөө, орон нутагт багшлах дадлага гүйцэтгэх суралцагчид тухайн сургуулийн нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний амьжиргааны зардал.

4.3. Сургалтын төлбөр, амьжиргааны зардлын хэмжээг Боловсролын болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

4.4. Сургалтын төрийн сан нь сургалтын төлбөр болон амьжиргааны зардал авах суралцагчтай гэрээ байгуулна. Энэхүү гэрээний загварыг Боловсролын болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

(Дэлгэрэнгүйг <http://sts.meds.gov.mn/index.php/mn/abase/254-2014-04-21-08-51-34>)

МУИС-ИЙН ДҮРЭМ ЖУРМЫН ТОВЬЁОГ

- МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёсзүйн дүрэм
- МУИС-н дүрэм
- МУИС-ийн сургалтын журам
- МУИС-ийн Төгсөлтийн дараах сургалтын журам
- МУИС-ийн Оюуны өмчийн талаарх баримтлах бодлого
- МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2014 онд УБ хотоос оюутан элсүүлэх журам (өдөр)
- МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2014 онд оюутан элсүүлэх журам (орой, эчнээ)
- МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт оюутан элсүүлэх түр журам
- МУИС-д Оюутан шилжүүлэн суралцуулах журам
- МУИС-ийн Оюутны дадлагын ерөнхий журам
- Сурган хүмүүжүүлэх дадлагын ерөнхий журам
- Байгалийн ухааны лабораторийн хичээл явуулах үйл ажиллагааны журам
- МУИС-д Гадаадын иргэнийг элсүүлэн суралцуулах журам
- ЭША-д амжилт гаргасан оюутанд МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг олгох журам
- МУИС-ийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийн журам

V БҮЛЭГ. СУРАЛЦАГЧИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ

СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ

Суралцагчийн дүнгийн голчийн үзүүлэлт аливаа тэтгэлэгт хөтөлбөрийн үндсэн шалгуур үзүүлэлт болдог бөгөөд тэтгэлэгт хөтөлбөр бүр өөр өөрийн онцлог, зорилгоос шалтгаалан тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын хувьд харилцан адилгүй байна. МУИС-д сайн суралцаж, эрдэм шинжилгээ, судалгаа, олон нийтийн ажилд амжилт гаргаж буй оюутнуудын сурах бололцоог хангах, тэднийг дэмжих зорилгоор гадаад дотоодын олон байгууллага, хувь хүмүүс тэтгэлэг олгодог. Тэтгэлэг нь дотоод, гадаад эх үүсвэрээс олгогдож байна.

Дотоодын тэтгэлэг:

- Сургалтын төрийн сан
- Хүний хөгжил сан
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг
- Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг
- МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг
- Монгол судлаач гадаад иргэдийг дэмжих МУИС-ийн тэтгэлэг
- Бусад тэтгэлэгүүд

Гадаадын тэтгэлэг

- Япон улсын Сумитомо корпорацийн нэрэмжит тэтгэлэг
- Япон улсын Мицibuши Корпорацийн нэрэмжит тэтгэлэг
- БНСУ-ын Поско сангийн нэрэмжит тэтгэлэг
- Тайваний иргэн Юни Уртагийн тэтгэлэг
- Бусад тэтгэлэгүүд

Дээрх тэтгэлгүүдийн тавигдах болзол, нөхцлүүд, зарлагдах хугацаа нь өөр өөр тул тухайн үед бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын албад болон МУИС сайт <http://www.num.edu.mn/> мөн оюутанд үйлчлэх төвийн www.facebook.com/muis.oyt/ хаягаар зарлана.

СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР

МУИС нь дэлхийн 170 гаруй их дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй бөгөөд тэдгээрийн нэлээд хэсэгтэй нь оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тус сургуулийн оюутан нь БНСУ, Япон Улс, БНХАУ, Тайвань гэсэн Азийн улсуудаас гадна ОХУ, Итали, Испани, Франц, Герман зэрэг Европын их дээд сургуулиудад урт болон богино хугацаагаар тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой байдаг. Оюутан солилцооны хөтөлбөрт бүх төрлийн мэргэжлээр жилд дунджаар 50 гаруй оюутан хамрагддаг.

Хөтөлбөртэй холбоотой мэдээлэл, зарыг цаг тухай бүрд нь МУИС-ийн <http://www.num.edu.mn/> хаягаар нээлттэй зарлана. Түүнчлэн studentaffairs@num.edu.mn хаягаар холбогдож солилцооны хөтөлбөрийн талаарх мэдээлэл авч болно.

Гадаадын их дээд сургуулийн солилцооны хөтөлбөрт хамрагдах оюутнууд дараах шаардлага хангасан байна. Үүнд

- Тэтгэлэгт хөтөлбөрт оролцогч нь зөвхөн МУИС-ийн оюутан байх,
- МУИС-ийн 2 болон 3-р курсын оюутан байна,
- Сурлагын голч дүн 3.0 болон түүнээс дээш байх,
- Суралцах хугацаандаа зөвхөн нэг удаа хөтөлбөрт хамрагдах,
- Гэрээтэй сургуулиудын тавьсан шаардлага хангасан байх,
- Англи болон бусад гадаад хэлний мэдлэгтэй байх,
- Мэргэжлээрээ өндөр ур чадвартай байх,
- Үнэнч шударга, ёс суртахууны хүмүүжилтэй байх зэрэг болно.

СУРАЛЦАГЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

МУИС нь Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараахи үйл ажиллагааг явуулдаг:

- Оюутныг хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай эрх зүй, хөдөлмөр, нийгмийн хамгааллын зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт явуулах, гарын авлага материал бэлтгэх
- Оюутныг байнгын болон цагийн ажлын байрны талаарх мэдээллээр хангах
- Оюутныг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах, төгсөгчдийн ажлын байрны судалгаа хийж ажлын байраар хангахад туслах
- Бүртгэгдсэн оюутнууд болон төгсөгчдөд хөдөлмөр зуучлалын үйлчилгээ явуулах
- Ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллах, хүний нөөцийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулдаг.

МУИС нь ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагуудтай дараах чиглэлээр хамтран ажилладаг:

- Оюутныг байнгын болон цагийн ажлын байраар хангах,
- Тус сургуулийн төгсөгчдөөс хүний нөөцөө бүрдүүлэх,
- Оюутан дадлага хийх бололцоог нэмэгдүүлэх,
- Нийтийг хамарсан ажил зохион байгуулах,
- Хөдөлмөрийн харилцааны сургалт зохион байгуулах
- Үйлдвэрлэлийн шинэ техник технологийг сурталчлах гэх мэт.

МУИС-ийн НОМЫН САН

МУИС-ийн Төв номын сан нь хичээлийн II байранд дараах бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа, үйлчилгээг явуулж байна. Үүнд:

Эрдэм шинжилгээний фонд



Эрдэм шинжилгээний фонд нь 140000 гаруй боть номтой бөгөөд жилд дунджаар 6000 уншигчдад 13000 ном олгож үйлчилдэг. Тус фонд нь №153 тоот өрөөнд байрлах ба тус сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтан, докторант, магистрант, оюутнуудад гэрээр ном олгох үйлчилгээг үзүүлдэг.

Нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухааны номын уншлагын танхим



Тус уншлагын танхимд хүмүүнлэгийн шинжлэх ухааны /социологи, түүх, эдийн засаг, соёл урлаг, хэл шинжлэл, утга зохиол, гүн ухаан, сэтгэл судлалын/ чиглэлийн орос, монгол хэл дээрх 60000 орчим номын фондтой, 250 уншигчийн суудалтай бөгөөд оюутнуудад уншигчийн болон оюутны үнэмлэхийг үндэслэн номыг уншлагын танхим болон гэрээр олгоно. Мөн уншлагын танхимд байхгүй номыг уншигчийн захиалгын үндсэн дээр эрдэм шинжилгээний номын фондоос авч оюутанд үйлчилнэ.

Байгалийн шинжлэх ухааны номын уншлагын танхим

Тус уншлагын танхим нь физик, математик, геофизик, геологи, газарзүй, хими, биологи болоод техникийн шинжлэх ухааны чиглэлийн 43000 гаруй номын фондтой, 200 уншигчийн суудалтай бөгөөд оюутнуудад уншигчийн болон оюутны үнэмлэхийг үндэслэн номыг уншлагын танхим болон гэрээр олгоно. Мөн уншлагын танхимд байхгүй номыг уншигчийн захиалгын үндсэн дээр эрдэм шинжилгээний номын фондоос авч оюутанд үйлчилнэ.

Чөлөөт сонголттой гадаад номын уншлагын танхим

Уг уншлагын танхим нь 20000 гаруй номын фондтой, 60 уншигчийн суудалтай бөгөөд тус сургуулийн багш, эрдэм шинжилгээний ажилтан, аспирант, магистрант, ажилтан ажилчид, оюутнуудад гадаад хэл дээрх ном, сурах бичиг, диссертаци болон магистрын дипломын ажлыг чөлөөт сонголтын хэлбэрээр олгож үйлчилнэ.

Тогтмол хэвлэлийн уншлагын танхим

Уг уншлагын танхим нь 50 уншигчийн суудалтай бөгөөд 1950 оноос хойшхи монгол, орос хэл дээрх сэтгүүл, өдөр тутмын сонингоор уншигчдад ажлын болон оюутны үнэмлэхийг үндэслэн үйлчилнэ. Тус танхим нь жилд 50 гаруй нэрийн дотоод, гадаадын сонин сэтгүүл захиалан уншигчдын хүртээл болгож байна.

Компьютерийн танхим



болон электрон каталоги номын сан, ном зүйн Үүнд: Номын нэр, зохиогчийг ямар каталоогоос шүүх, холбогдолтой номын тухай, ажилтай холбогдсон

сэтгүүлээс олж болох гэх зэрэг асуултанд электрон каталоги, картын сан, лавлагааны материал ашиглан лавлагаа өгнө. Лавлагааг амаар болон бичгээр, номын сангийн цахим хуудсаар дамжуулан онлайн хэлбэрээр өгч байна. Мөн номын сангийн хэмжээнд фондын баяжилт хийгдэж байгаа шинэ номын мэдээг цаг тухай бүрт нь гаргаж сурталчилдаг.

Ном бүрдүүлэн, ажиллах тасаг



Уг танхим нь 15 уншигчийн суудалтай бөгөөд интернэтэд холбогдсон компьютер, принтерээр оюутнуудад оюутны үнэмлэхийг үндэслэн үйлчилж байна. Тус танхим нь төрөл бүрийн сургалтын холбогдолтой CD, DVD, гадаад дотоодын онлайн мэдээллийн сангуудыг ашиглах боломжийг уншигчдад олгож байна.

Каталоги, лавлагаа- номзүйн мэдээллийн тасаг

Энд төв номын сангийн монгол, орос, гадаад номын цаасан байрладаг. Уг тасаг нь уншигчдад холбоотой мэдээллээр үйлчилдэг. тодруулах, хэрэгцээт номоо тодорхой нэг сэдвийн мөн реферат болон дипломын материалыг ямар ном, сонин

Уг тасаг нь тус сургуулийн сургалт эрдэм шинжилгээний агуулга, хөтөлбөрт нийцсэн гадаад, дотоод ном, хэвлэлийн судалгааг хийж, номын фондын сан хөмрөгийг бүрдүүлж, шинээр ирсэн номонд номын сангийн техник үйл ажиллагааг хийж, электрон каталогт оруулан, уншлагын танхимуудад хуваарилан олгож, уншигчдад хүргэдэг. Мөн холбогдох санхүүгийн тайлан тооцоог гаргадаг.

Ном сэлбэн засах тасаг

Номын сангийн хэмжээний урагдаж гэмтсэн ном, сурах бичгийг сэлбэн засах, тогтмол хэвлэлийг он, улиралаар нь үдэж хавтаслах үйл ажиллагаа явуулдаг.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

Номын сангийн үйлчилгээний дотоод журамд заасны дагуу үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- Багш, ажилтан, докторант, магистрантуудад нэгээс дээш хувьтай номыг 7-10 хоногийн хугацаатай гэрээр олгох ба дараагийн уншигч тухайн номыг захиалаагүй тохиолдолд хугацааг сунгуулж болно.
- Фондод нэг хувь байгаа ном, гар бичмэл, диссертаци, диссертацийн хураангуй, магистрын дипломын ажил, тогтмол хэвлэлийг гэрээр олгохгүй зөвхөн уншлагын танхимаар олгоно.
- Төрөлжсөн уншлагын танхимууд оюутны болон уншигчийн үнэмлэхийг үндэслэн уншигчдад 1 удаа 5 хүртэлх номыг олгоно. Номын фондод байгаа 30-аас дээш хувьтай номыг оюутанд гэрээр олгож болно.
- Төрөлжсөн уншлагын танхимуудын ойрын фондод байхгүй номыг уншигч Эрдэм шинжилгээний номын фондоос захиалан авна.


НОМЫН САНГИЙН УНШИГЧИЙН ҮНЭМЛЭХ НЭЭЛГЭХ

Тус сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтан, ажилчид, докторант, магистрант, оюутануудад номын сангийн уншигчийн үнэмлэхийг нээж, номын сангийн Коха системд уншигчийн мэдээллийг оруулна.

Номын сангийн уншигчийн үнэмлэхийг чөлөөт сонголттой гадаад номын уншлагын танхимд /179А/ нээх бөгөөд дараах зүйлсийг бүрдүүлнэ. Үүнд:

1. Иргэний үнэмлэх
2. Ажлын болон оюутны үнэмлэх
3. Цээж зураг 1% /3x4/
4. Бүртгэлийн хураамж 1000 төгрөг

Электрон каталоги



МУИС-ийн Төв номын сан болон салбар сургуулиудын ОБДСТ-ийн номын мэдээллийг номын сангийн Коха системд оруулсан бөгөөд <http://catalog.num.edu.mn> хаягаар хандан интернэтэд холбогдсон ямар ч төхөөрөмжөөс хайлт хийх боломжтой. Мөн түүнчлэн уншигчдад электрон каталогийн үйлчилгээг хүртээмжтэй болгох үүднээс дөрвөн уншлагын танхимуудад электрон каталогийн хайлтын компьютер байрлуулсан.

Цахим хуудас

Манай номын сангийн цахим хуудас болох <http://library.num.edu.mn> хаяг руу хандан номын сантай холбогдох мэдээ мэдээлэл, шинэ номын мэдээ зэргийг үзэх мөн онлайн лавлагаа авах, санал хүсэлт, номын татгалзалаа өгөх боломжтой.

Онлайн мэдээллийн сан

МУИС-ийн интернэт сүлжээнд холбогдсон төхөөрөмж ашиглан дэлхийн нэр хүнд бүхий JStor, Cambridge, IMF elibrary, Springer зэрэг онлайн мэдээллийн системүүдийг ашиглах боломжтой.

Номын сантай танилцах өдөрлөг

Тус сургуульд шинээр элсэн орсон оюутнуудад зориулан номын сантай танилцах өдөрлөгийг жил бүрийн 9-р сард зохион байгуулдаг. Уг арга хэмжээний үеэр оюутнуудын 1-р ангидаа судлаж үзэх хичээлийн ном сурах бичиг болон шинэ номын үзэсгэлэн гаргах, номын сангаар хэрхэн үйлчлүүлэх талаарх мэдлэг, мэдээлэл олгох, номын сангийн дүрэм журам, электрон каталоги хэрхэн ашиглах талаар танилцуулах үйл ажиллагаа явуулдаг.

ДОТУУР БАЙР

МУИС нь оюутны зургаан байртай бөгөөд гадаадын 160, дотоодын 1600 оюутан хүлээн авах хүчин чадалтай. Дотуур байранд суух оюутны хяналтын тоог байрны багтаамжид тааруулан Хангамж үйлчилгээний хэлтсээс орон нутгаас шинээр элссэн оюутны хяналтын тоог үндэслэн, оюутны байранд амьдрах оюутнуудын хуваарийг бүрэлдэхүүн сургуулиудын захирал, сургалтын албанд хүргүүлнэ. Дотуур байранд суух, шинээр элссэн, хөдөө орон нутгийн оюутанг бүртгэхэд бүрдүүлэх материал:

- Байранд амьдрахыг хүссэн өргөдөл
- Орон нутгаас шинээр элсэгч МУИС-д суралцах гэрээний хуулбар эх, хувийн хамт
- МУИС-ийн оюутан /Өмнө нь байрны журмын болон сахилгын зөрчил гаргаж байгаагүй хоёрдугаар ангийн оюутан/
- Сургуулийн тодорхойлолт /Шинээр элсэгчдэд хамаарахгүй/
- Оюутны үнэмлэх /Шинээр элсэгчдэд хамаарахгүй/
- Цахим үнэмлэх, баталгаажуулсан хуулбар
- Бүтэн өнчин //эцэг, эхийн нас барсны гэрчилгээг үндэслэнэ/
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутан баг, хорооны тодорхойлолт

- Цээж зураг 3x4 хэмжээтэй 6% /Сүүлийн 3 сард авахуулсан ижил байх/
Хөгжлийн бэрхшээлтэй, Өнчин оюутны материалыг эхний ээлжинд хүлээн авна.

Оюутны байранд оюутан суух хүчин чадал

№	Байр	Хүчин чадал	Байршил	Холбоо барих
1.	Оюутны 1-р байр	260	УБ, СБД, Бага тойруу, 6-р хороо /Хичээлийн 2-р байрны хойно/	77307730-1163
2.	Оюутны 2-р байр	260	УБ, СБД, Бага тойруу, 6-р хороо /Хичээлийн 2-р байрны хойно/	77307730-1164
3.	Оюутны 3-р байр	356	УБ, СБД, 8-р хороо, Оюутны А хотхон	77307730-1165
4.	Оюутны 4-р байр /гадаад оюутны байр/	180	УБ, СБД, 8-р хороо /Дашчойлин хийдийн зүүн талд/	77307730-1166
5.	Оюутны 5-р байр	380	УБ, СБД, 8-р хороо Оюутны А хотхон	77307730-1167
6.	Оюутны 6-р байр /худалдааны дотуур/	364	УБ, СБД, 8-р хороо /спортын төв ордны зүүн талд/	77307730-1168

ЭМНЭЛЭГ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

МУИС-ийн дэргэдэх эмнэлэг нь оюутнуудад нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламжийг ерөнхий мэргэжлийн болон амны хөндийн эрүүл ахуйн чиглэлээр жигд хүртээмж, чанартай үзүүлэхийг эрхэмлэн ажилладаг. ЭКГ, УВЧ, ИСКРА, улагын аппарат бүхий эмчилгээний кабинет, 2 суудал бүхий солюкс шүдний кабинеттай ба Солонгос, Япон, Герман зэрэг орны шүдний эм бэлдмэл, яаралтай болон зайлшгүй шаардлагатай эм тариа бэлдмэлээр хангагдсан байдаг. Оюутнуудад ерөнхий мэргэжлийн үзлэг, эмчилгээ үнэ төлбөргүй ба шүдний эмчилгээ 20%-ийн хөнгөлөлттэйгөөр үйлчилнэ. Бүтэц, бүрэлдэхүүний хувьд:

- *Л.Алтанцэцэг, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан*
- *Ж.Эрдэнэцэцэг, Шүдний ахлах зэрэгтэй их эмч, АУ-ны магистр, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан, шүдний эмчилгээ, хиймэл шүдээр мэрэгшсэн*
- *Х.Аззаяа – сувилагч*
- *Пүрэвсүрэн нар ажилладаг.*

Тус эмнэлэг нь оюутны байранд амьдардаг оюутнуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор ОУ-ын болон сайн дурын байгууллагатай хамтран эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг МУИС-ийн Оюутны асуудал хариуцсан захиргааны нэгжтэй хамтран зохион байгуулдаг.

Мөн профессор багш, оюутнуудын эрүүл таатай орчинд ажиллаж сурах, амьдрах нөхцөл бололцоогоор хангах зорилгоор хичээлийн болон оюутны байруудад ариутгал устгал халдваргүйжлийн ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулдаг.

Тус эмнэлэгийн үйл ажиллагаа, хүчин чадлын хувьд:

- Өдөртөө 20-25 хүнд дотрын эмчийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, зөвөлгөө өгөх
- Бүх төрлийн тарилга хийх
- Шарх, шархлааны боолт хийх, цэвэрлэх
- Физик эмчилгээ, аппаратаар шарлага хийх /УВЧ, Искра, утлага/
- Шүдний оношилгоо, эмчилгээ, шүд авах 20-25 хүнд үйлчлэх
- Хиймэл шүд /авагддаг авагддаггүй/

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТӨВ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “Хууль зүйн клиник” хичээлийн хүрээнд оюутнууд нь эрүү, иргэн, захиргааны эрх зүйн багт хуваагдан, хуваарийн дагуу сэдэвчилсэн төлөвлөгөөт хичээлд хамрагдан хичээлийн бус цагаар “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв” болон www.Mongolianlaws.com цахим хуудсаар дамжуулан иргэдэд зөвлөгөө өгдөг юм.

Тус төв нь хууль, эрх зүйн тодорхой маргаантай, мэргэжлийн зөвлөгөө шаардлагатай асуудлаар төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх зорилготой бөгөөд оюутан та ч бас хандаж болно.

“Хууль зүйн зөвлөгөө өгөх төв” нь суралцагчдад дараах хэлбэрээр туслалцаа үзүүлнэ.

- Эрх зүйн асуудлаар зөвлөгөө өгөх,
- Хууль тогтоомжийн лавлагаа өгөх,
- Нэхэмжлэл, өргөдөл, гомдол, гэрээний төсөл зэрэг баримт бичгийг боловсруулж өгөх,
- Шүүхийн өмнөх шатанд үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах,
- Шүүхэд төлөөлөх гэх мэт

<http://www.Mongolianlaws.com> *сайтаар дамжуулан* хууль зүйн зөвлөгөө авах тохиолдолд ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ гэсэн цонхонд асуулт болон өөрийн e-mail хаягаа бүрэн, зөв, тодорхой бичиж илгээхэд л болно. Таны асуултанд дурьдагдсан асуудлаар МУИС-ын Хууль зүйн сургуулийн Практик сургалтын тэнхимийн “Хууль зүйн клиник сургалт”-нд хамрагдаж, тухайн эрх зүйн чиглэлээр мэргэшиж буй ахлах ангийн оюутнууд (багшийн удирдлаган дор) судалгаа хийж, хариултыг дээрх сайтад бүртгүүлсэн e-mail хаяг руу тань 7 хоногийн дотор илгээх болно.

Харин хууль, эрх зүйн энгийн ойлголтуудын талаар тодорхойлолт өгөх, эсхүл эрх зүйн онолын ойлголтын талаар тайлбар гаргаж өгөх үйлчилгээ үзүүлдэггүй.

СЭТГЭЛ ЗҮЙН ОНОШИЛГОО, СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ТӨВ

Тус төв нь:

- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх,
- Сэтгэл засал хийх,
- Сэтгэл зүйн оношлогоо хийх,
- Стресс тайлах,
- Сэтгэл зүйн боловсрол, сэтгэцийн эрүүл мэндийн сургалт явуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал: сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал нь ганцаарчилсан, гэр бүлийн, бүлэг хамт олны хэлбэртэй.

Сэтгэл зүйн оношилгоог компьютерийн болон энгийн аргаар дараах чиглэлээр хийдэг. Үүнд:

- Харилцааны үр чадварын төвшинг тогтоох,
- Зан төлөв, авир араншингийн онцлогийг тодорхойлох,
- Оюуны коэффициентийг тогтоох,
- Авьяас чадварын чиглэлийг гаргах,
- Мэргэжлийн чиг баримжаа, мэргэжил сонголтын чиглэлийг тогтоох,
- Стрессийн төвшинг илрүүлэх, түүний шалтгааныг тогтоох,
- Эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийх.

Тус төвийн онцлог нь:

- Мэргэжилтнүүд нь сэтгэлзүйчийн нарийн мэргэжлийн диплом бүхий эрдмийн зэрэг цолтой, мэргэжлээрээ дагнан ажилласан олон жилийн туршлагатай, гадаад дотоодын сургалтанд хамрагдсан, их, дээд сургуулиудад олон жил багшилсан, уг ажлыг эрхлэх эрхийн гэрчилгээтэй болно.
- Компьютерийн тестээр сэтгэцийн эрүүл мэнд, өөрчлөлтийн оношилгоог хийдэг цөөн байгууллагын нэг.

- Бидний хэрэглэж буй компьютерийн оношилгоо нь батлагдсан стандартын дагуу зохиогдсон албан ёсны, хэрэглэх зөвшөөрөлтэй юм. Тухайлбал, бид бие хүний шинжийг тодорхойлох MMPI тест, стрессийн илрэл, шалтгааныг илрүүлэх Люшерийн тест, бие хүний 16 хүчин зүйлийн Кеттелийн тестийн хувилбарыг хэрэглэж байна. Мөн манай төвийн мэргэжилтнүүд эмгэг сэтгэл судлалын нарийн шинжилгээ хийж байна.

Тус төв ижил чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын зарим байгууллагуудтай холбоотой ажилладаг. Тухайлбал, Оросын Холбооны Улсын Санкт-Петербург хотын хэрэглээний сэтгэл судлалын “Иматон” хүрээлэнд манай зарим мэргэжилтэн богино хугацааны сургалтанд хамрагдан компьютерийн тестээр сэтгэц оношилгоог явуулах эрхийн гэрчилгээ авсан болно.

**VI БҮЛЭГ. ШААРДЛАГАТАЙ УТАС БОЛОН ХИЧЭЭЛИЙН БАЙР,
ӨРӨӨНИЙ ДУГААР**

Байр/ Өрөөний №	Албан тушаал	Дотуур	Ажлын утас
Сургалтын нэгдсэн алба			
1-211	Дарга	1023	320892
1-213	Сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн	1162	
	Хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн	1124	
	Цахим сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн	1144	
	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	1121	
	Элсэлт төгсөлт, шилжилт хариуцсан мэргэжилтэн	1196	
	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн	1125	
	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	1139	
	Мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1125	
	Оюутны үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1143	
Гадаад оюутан хариуцсан мэргэжилтэн			
Мэдээллийн технологийн алба			
1-120	Дарга	3344	312829
1-120	Хэрэглэгчдэд үйлчлэх мэргэжилтэн	1153	
1-210	МУИС-ийн хэвлэлийн төлөөлөгч	1187	
Номын сан			
2-250	Номын сангийн захиргаа	1157	
2-179А	Чөлөөт сонголттой гадаад номын уншлагын танхим	1159	
2-179	Компьютерийн танхим		
2-153	Каталоги, лавлагаа номзүйн тасаг	1204	
2-156	Тогтмол хэвлэлийн уншлагын танхим		
2-153	Эрдэм шинжилгээний фонд	1204	
2-286	Нийгмийн шинжлэх ухааны номын уншлагын танхим	1160	
2-351	Байгалийн шинжлэх ухааны номын уншлагын танхим	1161	
2-286	Ном бүрдүүлэн ажиллах тасаг	1205	
2-286	Ном сэлбэн засах тасаг	1205	
Шинжлэх ухааны сургууль			
2-365	Захирлын туслах	2301	325435
2-448	Сургалтын албаны эрхлэгч	2703	
2-271	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	2324	
		2515	
2-261	Элсэлт төгсөлт, шилжилт хариуцсан мэргэжилтэн	1502	
		6115	
		2102	
2-260	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн	2502	
		2303	
2-261	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	2717	
		1309	
2-260	Зааварлагч	2719	
		6115	
Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль			
3-211	Захирлын туслах	3301	325631
3-101	Сургалтын албаны эрхлэгч	3302	
3-208	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	3102 3115	
3-208	Элсэлт төгсөлт, шилжилт хариуцсан мэргэжилтэн	3115	

3-208	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн	3102	
3-230	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	3301	
3-230	Зааварлагч	6101 3313	
Бизнесийн сургууль			
4-201	Захирлын туслах	4101	11320277
4-202	Сургалтын албаны эрхлэгч	4102	
	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	4133	
	Элсэлт төгсөлт, шилжилт хариуцсан мэргэжилтэн		
	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн		
	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн		
Зааварлагч			
Хууль зүйн сургууль			
3-309	Захирлын туслах	3502	329680
3-206	Сургалтын албаны эрхлэгч	3503	312600
	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	3518	
	Элсэлт төгсөлт, шилжилт хариуцсан мэргэжилтэн	3503	
	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн	3518	
	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	3503	
	Зааварлагч	3503	
Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль			
5-204	Захирлын туслах	5101	354610
5-203	Сургалтын албаны эрхлэгч	5102	5103
	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	5103	
	Элсэлт төгсөлт, шилжилт хариуцсан мэргэжилтэн		
	Сургалтын технологи хариуцсан мэргэжилтэн		
	Оюутны бүртгэл хариуцсан мэргэжилтэн		
	Зааварлагч		

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ, САЛБАР НЭГЖИЙН ХАЯГ

Шинжлэх ухааны сургууль

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 47,
МУИС-ийн хичээлийн II байр, 260 тоот
Утас: 77307730 – 2719 /Сургалтын алба/
Email: sas@num.edu.mn
<http://sas.num.edu.mn>

Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль

Builind №3, Ikh surguulin gudamj-3
Sukhbaatar District, P.O.Box -46A/600
Ulaanbaatar 14201, Mongolia
Tel: 976-11-324007
Fax: 976-11-325305
Email: seas@num.edu.mn
<http://seas.num.edu.mn>

Бизнесийн сургууль

МУИС-ийн хичээлийн 4-р байр, Бага тойруу-4,
СБД, УБ хот Улаанбаатар 46а,
шуудангийн хайрцаг 460,
Сургалтын алба 976-11-350277
Захирлын туслах 976-11-350994
И-мэйл хаяг: bsro@num.edu.mn
Вэб хуудас: bs.num.edu.mn

Хууль зүйн сургууль

Монгол улс, Улаанбаатар хот,
 Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж-3,
 МУИС-ийн хичээлийн III байр
 Утас: 11 - 312600, 77307730 - 3503 /Сургалтын алба/
 Факс: 976-11-329680
 Э-шуудан: lawschool @ num.edu.mn

Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 1
 МУИС-ийн хичээлийн v байр
 Утас:(976-11) 354610, 77307730-5101 /захирлын туслах/
 (976-11) 354618, 77307730-5102, 5103 /Сургалтын алба/
 Факс: (976-11) 354610
 Шуудангийн хаяг: Улаанбаатар-46-А ш/х 6
 И-майл хаяг: irpa@num.edu.mn

Сургалтын нэгдсэн алба

МУИС-ийн хичээлийн I байр,
 Их Сургуулийн гудамж - 1, Бага тойруу,
 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
<http://num.edu.mn>
our@num.edu.mn,

МУИС-ийн Номын сан

МУИС-ийн хичээлийн II байр,
 Их Сургуулийн гудамж - 1, Бага тойруу,
 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
 Ulaanbaatar-46A BOX-07 Library of NUM
<http://library.num.edu.mn>
<http://catalog.num.edu.mn>
num_library@num.edu.mn,
muis_library@yahoo.com

Номын сангийн цагийн хуваарь

	Даваа-Баасан	Бямба	Ням
Уншлагын танхимууд			
ЭШНФ	09 ⁰⁰ -20 ⁰⁰	09 ⁰⁰ -17 ⁰⁰	-
Компьютерын танхим			
Лавлагаа, номзүй			
Ном бүрдүүлэх тасаг	09 ⁰⁰ -18 ⁰⁰		-
Сэлбэн засах тасаг			

Өвөл, хаврын шалгалтын үеэр ажиллах цагийн хуваарь

	Даваа-Ням
Уншлагын танхимууд	
ЭШНФ	09 ⁰⁰ -20 ⁰⁰

Дотуур байр

№	Байр	Байршил	Холбоо барих
1	Оюутны 1-р байр	УБ, СБД, Бага тойруу, 6-р хороо /Хичээлийн 2-р байрны хойно/	77307730-1163
2	Оюутны 2-р байр	УБ, СБД, Бага тойруу, 6-р хороо /Хичээлийн 2-р байрны хойно/	77307730-1164
3	Оюутны 3-р байр	УБ, СБД, 8-р хороо, Оюутны А хотхон	77307730-1165
4	Оюутны 4-р байр /гадаад оюутны байр/	УБ, СБД, 8-р хороо /Дашчойлин хийдийн зүүн талд/	77307730-1166
5	Оюутны 5-р байр	УБ, СБД, 8-р хороо Оюутны А хотхон	77307730-1167
6	Оюутны 6-р байр /худалдааны дотуур/	УБ, СБД, 8-р хороо /спортын төв ордны зүүн талд/	77307730-1168

МУИС-ийн Эмнэлэг

Хаяг: МУИС-ийн оюутны I байрны I давхарт
Утас: 319077, 77307730-1076, 77307730-1075

Хууль зүйн зөвлөгөө өгөх төв

Хаяг: МУИС-ийн хичээлийн 3 дугаар байр, Хууль зүйн сургууль, Практик сургалтын тэнхим
Утас: 11-310524, 77307730-3508

Сэтгэл зүйн оношилгоо, сургалт, судалгааны төв

Хаяг: Хичээлийн II байр, НШУС, 475 тоот
Утас: 77307730-2315